

2018 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын нэр: “2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”



2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

	Товчилсон үгийн тайлбар	3
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4
Дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа	<i>БҮЛЭГ 1. Төсвийн зарлагын төлөвлөлтөд төсвийн удирдамж, аргачлалын холбогдох заалтыг баримтлахгүй байгаагаас орон тоо, цалингийн санг хэтрүүлэх, хөрөнгийн зардлыг буруу төлөвлөх зэрэг зөрчил гарч байна.....</i>	<i>5-13</i>
Аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа	<i>БҮЛЭГ 2. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний сар улирлын хуваарийг мөрдөж ажиллаагүй байна.....</i>	<i>14-20</i>
Ахлах аудитор Л.Аваадорж	<i>БҮЛЭГ 3. Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй байна.....</i>	<i>21-29</i>
Аудитор Б.Тунгалагтуяа	<i>БҮЛЭГ 4. Аймаг сумын ИТХ-аас төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшинг батлаагүйгээс хүрэх үр дүнг хэмжих үзүүлэлт байхгүй байна.....</i>	<i>30-32</i>
2018 оны 10 дугаар сарын 31		
Утас: 7052-2734, 7052-3020	Дүгнэлт.....	33-35
Факс: 7052-2734	Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал.....	36
Хаяг: Сайншанд сум 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн 3-р байр 201, 202 тоот	Зөвлөмж.....	37-38
	Холбогдох байгууллагын санал.....	
	Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар.....	
	Аудитын тайлан баталгаажуулсан тушаал.....	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд “2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д санхүүгийн аудит хийв.

Аудитын зорилго, зорилт:

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган, УИХ, аймгийн ИТХ-д аудитын дүнг танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх;
- 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх;
- ТЕЗ-чдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх.

Хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа орон нутгийн төсөвт болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд, аймгийн Орон нутгийн өмчийн газар, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон сумдын санхүүгийн албаны 2018 оны 1-3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэл, тайлан мэдээ, анхан шатны баримт материалыг түүвэрлэн хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, санхүүгийн аудитын болон гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, судалгаа дүн шинжилгээ болон харьцуулалт хийх, тулган баталгаажуулах зэрэг аргазүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**Бүлэг
1**

Төсвийн зарлагын төлөвлөлтөд төсвийн удирдамж, аргачлалын холбогдох заалтыг баримтлахгүй байгаагаас орон тоо, цалингийн санг хэтрүүлэх, хөрөнгийн зардлыг буруу төлөвлөн зарцуулах зэрэг зөрчил гарч байна.

1.1. Хөрөнгийн болон хөрөнгө борлуулсны орлогыг төлөвлөөгүй байна.

Сангийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 4-1/4116 тоот албан бичгээр “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018-2020 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж”-ийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2012 оны 44 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 2.1.4-т төсвийн төсөл боловсруулахад төсвийн удирдамжийг баримтална гэж заасан.

Төсвийн удирдамжийн 4.1.2-т **“төсвийн орлогыг төлөвлөхдөө тооцоо судалгаагүй, бодитой бус орлого төлөвлөхгүй байхад онцгой анхаарах”** гэсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06/02 тогтоолоор аймгийн төсвийн татварын орлогыг 13,418.4 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 3937,8 сая төгрөгөөр, нийт орлогыг 17,356.2 мянган төгрөгөөр баталсан байна. Аймгийн ИТХ-аар төсвийн орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 3,682.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн ба үүнд татварын орлогоос 589.8 сая төгрөг, татварын бус орлогоос 14.7 сая төгрөг, газрын дуудлага худалдаанаас 3,077.7 сая төгрөг нэмж олохоор тооцжээ.

Орлогын нэмэгдсэн дүнгийн 83.6 хувь буюу 3,077.7 сая төгрөгийг газрын дуудлага худалдааны орлогоос нэмж олохоор тооцсон. 2018 оны 3-р улирлын газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөний биелэлт 84.6 хувьтай буюу нийт 15.4 хувиар төлөвлөгөө тасарсан байдалтай байна.

Төсвийн тухай хуулийн 23.6-д зааснаар аймаг, нийслэлийн төсвийн татварын орлогод нийт 9 нэр төрлийн орлого төвлөрдөг байхаар заасан ба эдгээрээс газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 20 хувийг аймгийн төсөвт огт төлөвлөж хуваарилахгүй явж ирсэн байна. Өнгөрсөн 2017 оны 10 дугаар сард энэ орлогыг төлөвлөж тусгах талаар манай байгууллагаас аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлсэн ба аймгийн Засаг даргаас Сангийн сайдад хандан газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг 2018 оны төсөвт тусгаж өгөхийг хүссэн боловч хариу ирүүлээгүй байна.

Сумдын ИТХ-аар сумдын төсөвт татварын орлогоос 5,602.4 сая төгрөг, татварын бус орлогоос 1,481.8 сая төгрөг, нийт 7,084.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр

баталсан байна. Сумдын ИТХ төсвийн орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 818.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн ба үүнд татварын орлогоос 360.6 сая төгрөг, татварын бус орлогоос 458.0 сая төгрөг нэмж олохоор тооцсон байна.

Төсвийн орлогыг төлөвлөхдөө аймгийн Татварын хэлтэс өөрийн систем дэх татвар төлөгчдийн мэдээлэл, өмнөх оны гүйцэтгэл зэрэгт тулгуурлан аймаг, сумын татварын орлогыг төлөвлөн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлдэг байна. Сумын төсвийн орлогыг төлөвлөх үйл явцад сумын төрийн сан, санхүүгийн албаны оролцоо бараг байхгүй байна.

Сумдын төсөвт төвлөрч байгаа хувь хүний орлогын албан татварыг хуулийн дагуу үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, шууд бус орлого зэргээр ангилдаг байна. **Сумдын төсвийн орлогын гүйцэтгэлээс үзвэл хөрөнгө борлуулсны орлого, хадгаламжийн хүүгийн орлогыг 2018 онд төлөвлөөгүй бөгөөд аудитад хамрагдсан сумдын санхүүгийн албанаас үйл ажиллагааны орлого, шууд бус орлогын төлөвлөгөөнд тусгасан гэж тайлбар өгсөн.**

Хадгаламжийн хүүгийн орлого нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу хөрөнгийн орлогод хамаарахаар байгаа бөгөөд орлогын энэ нэр төрлөөр төлөвлөж, тайлагнасан орлого байхгүй байна.

2018 оны 3-р улирлын байдлаар орлогын төлөвлөгөөгүй 171.4 сая төгрөгийн хөрөнгө борлуулсны орлого тайлагнагдсан байна Алтанширээ, Сайхандулаан, Хөвсгөл сум хөрөнгө борлуулсны орлогын гүйцэтгэл гаргаагүй байна. Хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг доор хүснэгтэд харуулав.

Хөрөнгө борлуулсны орлого /2018.09.30/

Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Айраг	0	1.9
Даланжаргалан	0	0.7
Дэлгэрэх	0	0.2
Замын-Үүд	0	87.1
Иххэт	0	0.3
Мандах	0	0.4
Өргөн	0	1.9
Сайншанд	0	77.9
Улаанбадрах	0	0.4
Хатанбулаг	0	0.3
Эрдэнэ	0	0.3
Нийт дүн (сая төг)	0	171.4

Эх сурвалж: Сангийн яамны 2018 оны 9-р сарын төсвийн орлогын мэдээ

Сайншанд, Замын-Үүд сумын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөө өмнөх онд 66-87 хувьтай биелж, орлогын төлөвлөгөө тасарсан байхад 2018 онд орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 24-25 хувиар нэмж төлөвлөсөн байна.

Замын-Үүд, Сайншанд сумын хог хаягдлын
хураамжийн орлогын төлөвлөгөө /сая төг/

Сумын нэр	Өмнөх оны төлөвлөгөө	2018 оны төлөвлөгөө	Нэмэгдсэн дүн /сая/	Нэмэгдсэн хувь
Замын-Үүд	97.7	122.2	24.5	25
Сайншанд	150.3	186.4	36.1	24

Төлөвлөгөөг үндэслэлгүй нэмэгдүүлснээс шалтгаалж дээрх 2 сумын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөө 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 47-72.5 хувиар тасраад байна. Сайншанд, Замын-Үүд сумын санхүү, төрийн сангийн тасгийн дарга нарын гаргаж өгсөн тайлбараас үзвэл Татварын албанаас уг орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөж өгснөөс шалтгаалан төлөвлөгөө тасарч байна гэж үзсэн байна. Иймд цаашид сумдын төсвийн орлогыг төлөвлөхдөө татварын байгууллагаас сумын Санхүүгийн албатай зөвшилцөн орлогыг үндэслэлтэй төлөвлөхөд анхаарах шаардлагатай байна.

1.2. Засгийн газраас тогтоосон орон тооны дээд хязгаарыг хэтрүүлсэн. Мөн орон тоо, цалингийн сангийн талаар баримтлах төсвийн удирдамж, аргачлалыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Сангийн сайдын ирүүлсэн 2018 оны төсвийн удирдамжийн 2.6. “бүтцийн өөрчлөлт, бусад шийдвэрээр орон тоо, урсгал зардал нэмэгдүүлэхгүй байх”, 4.2.14-т “ажлын ачааллыг нягтруулах замаар одоо мөрдөгдөж байгаа орон тоог нэмэгдүүлэхгүй байх зарчим баримталж, орон тоо, цалингийн санг төлөвлөх” гэж заасан байна.

Сангийн яамнаас тус аймагт нийт 188 байгууллагын 2576 албан хаагч ажиллахаар 20.5 тэрбум төгрөгийн цалингийн сан баталж өгсөн байна. Аймгийн ИТХ-аар нийт 194 байгууллагын 3003 албан хаагч ажиллахаар баталж, орон тоог нийт 427 албан хаагчаар нэмэгдүүлж, цалингийн санг нийт 2.2 тэрбум төгрөгөөр өсгөжээ. /орон тооны нэмэгдсэн өөрчлөлтийг хүснэгтэд харуулав/

Байгууллагын нэр	Сангийн яам	Аймгийн ИТХ	Нэмэгдсэн тоо
Байгууллагын тоо	188	194	6
Ажиллагсадын тоо	2,576	3,003	427
Удирдах ажилтан	197	229	32
Гүйцэтгэх ажилтан	1,479	1,675	196
Үйлчлэх ажилтан	754	851	97
Гэрээт ажилтан	146	248	102

Байгууллагын тоо нэмэгдсэн нь Замын-Үүд, Сайншанд, Хатанбулаг сумдын захирагчийн ажлын алба, Замын-Үүд сумын Хот тохижилтын байгууллага, Иххэт сум

болон Зүүнбаян багийн спорт цогцолбор гэсэн 6 байгууллага нэмэгдсэнээ шалтгаалжээ.

Нийт төсвийн байгууллагын ажиллагсадын орон тооны хувьд аймгийн ЗДТГ-10, сумдын ЗДТГ-109, Хот тохижилт 109, сумдын сургууль 108, цэцэрлэг 12 орон тоо нэмэгдүүлсэн нь орон тооны өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Харин өрхийн эмнэлгийн орон тоо Сангийн яамны төлөвлөгөөнд тусгагдаагүй байсныг аймгийн төлөвлөгөөнд тусгасан нь орон тоо 59 албан хаагчаар нэмэгдсэн мэт харагдуулж байна.

Байгууллагын нэр	Сангийн яам	СТСХ /2018.09.30/	Нэмэгдсэн орон тоо
Аймгийн ИТХ	7	9	2
Сумын ИТХ	28	31	3
Аймгийн ЗДТГ	67	77	10
Сумын ЗДТГ	375	484	109
Хот тохижилт	24	133	109
БОАЖГ	18	18	0
СХААлба	6	7	1
ОНӨГ	7	7	0
Гэр бүл ХЗХГ	19	19	0
Газрын харилцаа	29	29	0
Цэцэрлэг	609	621	12
ЕБС	989	1097	108
Сумын эмнэлэг	228	228	0
ӨЭМТөв	0	59	59
БТСГ	12	12	0
Музей	15	15	0
Номын сан	12	12	0
Театр	50	50	0
Сумын соёлын төв	81	95	14
нийт орон тоо	2576	3003	427

Сумдын ЗДТГ-ын багийн албанд хэсгийн ахлагч 65, бусад гэрээт ажилтан 26, гурван сумын захирагчийн албанд 9 орон тоо, Сайншанд болон Замын-Үүд сумын Хот тохижилтын газарт 109 гэрээт ажилтан нэмж ажиллуулсан нь орон тоо, цалингийн санг өсгөх гол шалтгаан болсон байна.

Сумдын ЗДТГ-ын орон тоог Засгийн газраас тогтоосон орон тооны дээд хязгаартай харьцуулбал нийт 102 орон тоогоор илүү байна. Доорх хүснэгтэд сум тус бүрээр харуулав.

Сумын нэр	Хүн ам	ЗГ-ын тогтоосон дээд хязгаар	Батлагдсан орон тоо	Хэтрэлт
Айраг	3811	16	21	5
Алтанширээ	1327	13	21	8
Даланжаргалан	2749	15	21	6
Дэлгэрэх	1873	15	21	6
Иххэт	2108	15	21	6
Мандах	1587	15	21	6
Өргөн	2004	15	21	6
Сайхандулаан	1380	13	21	8
Улаанбадрах	1470	13	21	8
Хатанбулаг	2919	15	21	6
Хөвсгөл	1573	15	21	6
Эрдэнэ	2378	15	21	6
Сайншанд	24772	23	35	12
Замын-Үүд	18241	21	34	13
Нийт дүн /тоо/	68192	219	321	102

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол, сумдын ЗДТГ-ын төсвийн төсөл

Сумдын ЗДТГ орон тооны тогтоосон дээд хязгаарыг хэтрүүлснээс гадна Багийн албаны гэрээт ажилтны орон тоог ихээр нэмэгдүүлсэн нь Багийн албаны орон тооны хязгаар байхгүйтэй холбоотой байна. Мөн гэрээт ажилтны талаар баримтлах орон тооны хязгаар, дүрэм журам байхгүй байна.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 3.1.1-т “*захиргааны ажил, үүрэг гүйцэтгэх албан хаагчийн орон тооны нормативыг эрх бүхий байгууллагаас баталсан жишиг хязгаар эсхүл орон нутгийн төрийн нийтийн албаны байгууллагын орон тоог тогтоосон эрх бүхий байгууллагын хамгийн сүүлд гарсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа шийдвэрийг үндэслэнэ*” гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Сургууль, цэцэрлэгийн хувьд шинээр 4 цэцэрлэг, 1 дотуур байр баригдсан болон нэгдүгээр ангид элсэх хүүхдийн тоотой холбоотой бага ангийн багшийн орон тоог нэмэгдүүлэх зэрэг шалтгаанаар 120 орон тоог нэмжээ.

Засгийн газар 2017 оны 188 дугаар тогтоолоор “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 оны төсвийн хязгаар”-ыг баталсан. Үүнд улсын төсвийн болон нийгмийн даатгалын сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн орлогын доод, зарлагын дээд хязгаарыг баталжээ.

Засгийн газраас орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн зарлагын дээд хязгаарыг тогтоож өгөөгүйгээс баримтлах төсвийн хязгаар байхгүй байна.

Ийнхүү аймаг, сумдын төсвийн ерөнхийлөн захирагч нар нь зарлагын дээд хязгаар байхгүйгээс төсвийн зарлагыг орлогоо нэмсэн хэмжээгээр нэмэгдүүлэн батлуулж байна. Үүний улмаас орон нутгийн ТЕЗ-ийн төсөв нь

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, 31 дүгээр зүйлийн 31.1.3-т заасан “ТӨЗ-ийн төсвийн төсөл нь жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх, төсвийн хязгаарт багтаасан байх” гэсэн шаардлагуудыг хангахгүй болж байна.

Мөн хуулийн 31.3-т “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 31.1-д заасан шаардлагыг хангаагүй төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг буцаана” гэсэн заалт хэрэгжихгүй байх нөхцөл үүссэн байна.

1.3. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын урсгал зардлыг илүү төлөвлөн батлуулсан байна.

Сангийн сайдын ирүүлсэн 2018 оны төсвийн удирдамжинд төсвийн зарлагын хувьд төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх гэсэн зарчмыг тусгасан.

Аймгийн ИТХ-аар Сангийн яамны хянаж ирүүлсэн төсвийн зарлагыг 5,606.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн ба үүнээс урсгал зардалд 2,684.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 2,921.7 сая төгрөг нэмж төлөвлөсөн байна.

Дорноговь аймгийн 2018 оны төсвийн зарлагын
төлөвлөгөөний өөрчлөлт /сая төг/

Нэр төрөл	Сангийн яам	Аймгийн ИТХ	Нэмэгдсэн дүн
Урсгал зардал	46,235.9	48,920.6	2,684.7
Хөрөнгийн зардал	6,539.8	9,461.5	2,921.7
нийт дүн	52,775.7	58,382.1	5,606.4

Зардлыг нэмэгдүүлсэн 5,606.4 сая төгрөгийн эх үүсвэрийг авч үзвэл төсвийн тэнцлийн ашгаас 1,416.1 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 500.0 сая төгрөг, татварын болон татварын бус орлогыг нэмсэн дүнгээс 3,690.3 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэхээр тооцжээ. Урсгал зардлын нэмэгдсэн дүнгийн 83.5 хувийг цалин хөлсний зардал, үлдэх хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр гэсэн зардал эзэлж байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн санхүүжилт нийт 30,984.6 сая төгрөгөөр батлагдсан ба орлогын шилжүүлгээс 30,907.7 сая төгрөг, өөрийн орлогоос 76.9 сая төгрөгөөр санхүүжихээр төлөвлөжээ. Үүнд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд дотор сургуулиудын санхүүжих дүн 17,103.9 сая төгрөг байна.

Сумын сургуулиудын төсвийн нийт санхүүжилтийн дүнд аймгийн Санхүү хэлтэс гэсэн нэр дээр Сайншанд суманд шинээр баригдах 320 хүүхдийн бага сургуулийн урсгал зардалд 1,607.5 сая төгрөгийг аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Энэ нь Сайншанд суманд баригдах 320 хүүхдийн бага сургуулийн урсгал зардал бөгөөд

УИХ-аас 2018-2019 онд барилгыг барьж дуусган ашиглалтанд оруулахаар батлагдсан байна.

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад дээрх сургуулийн нийт төсөвт өртөг 2.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнээс 2018 онд 700.0 сая төгрөгөөр санхүүжих, үлдэгдлийг дараа онд санхүүжүүлэхээр байна. **Төсвийн төлөвлөлтөнд тавих хяналт сул байгаагаас дараа онд ашиглалтанд орох бага сургуулийн урсгал зардлыг илүү төлөвлөн батлуулжээ.**

Мөн сумдын Эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдийн төсөвт “төрийн сангийн нөөц” нэрээр 18.5 сая төгрөгийг илүү хуваарилан батлуулсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв “төсвийн төвлөрүүлэн захирагч”-ийн буюу аймгийн нийт дүнгээр батлагдан ирдэг ба үүнийг аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагийн газрын төсвийн мэргэжилтнүүд төсвийн шууд захирагч бүрээр хуваарилан аймгийн СТСХ-т хүргүүлдэг байна. Ингэж аймгийн ЭМГ, БСУГ-аар дамжин төсвийн хуваарилалт хийгдсэнээс сумдын ТЗШ-ийн байгууллагуудын төсвийн хэмнэлт үүсгэх, хооронд нь шийдвэргүйгээр шилжүүлэх зэрэг зөрчил гаргаж байна.

Дээрх үйлдэл нь сумын ИТХ-ын баталсан сумын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв болон төсвийн сар улирлын хуваарь хоорондоо зөрүүтэй батлагдах, сумын Засаг дарга өөрийн харьяа байгууллагуудын төсвийг хуваарилах, батлах зэрэг хууль тогтоомжоор олгогдсон эрхээ хэрэгжүүлж чадахгүй байх нөхцөл байдалд хүргэж байна.

Тухайлбал Төсвийн тухай хуулийн 61.3. “сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагыг төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацааны дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, мөн хуулийн 66.1.6-д зааснаар сумын Засаг дарга тухайн шатны төсвийг боловсруулах, батлуулах, төсвийн сар улирлын хуваарийг баталж мөрдүүлэх бүрэн эрхтэй гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.4. Хөрөнгийн зардлыг буруу төлөвлөн зарцуулж байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-д “орон нутгийн төсвийн суурь зарлага” гэж энэ хуулийн 58.2.1, 58.4.1-т заасан /аймаг, сумын удирдлагын/ чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, энэ хуулийн 58.2.4, 58.2.13, 58.4.2, 58.4.6-д заасан /халамж, байгаль орчны/ чиг үүрэгтэй холбогдох урсгал зарлагын нийлбэрийг ойлгоно гэж заасан.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 1.2.3-т **“орон нутгийн /аймаг, сумын/ удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал”** гэж аймаг,

сумын ИТХ, ЗДТГ, Баг болон Засаг даргын шууд харьяанд байгаа орон нутгийн төсөвт байгууллагын үйл ажиллагааны урсгал болон хөрөнгийн зардлын нийлбэрийг ойлгоно гэж тодорхойлсон.

Сангийн яамны хянаж ирүүлсэн 2018 оны төсвийн төслөөр **суурь зарлагад тооцох орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардалд** 2,564.2 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд үүнийг аймгийн ИТХ-аар 3,654.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 6,218.2 сая төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн хөрөнгө оруулалтад 5,594.2 сая төгрөг, замын санд 624.0 сая төгрөг хуваарилахаар төлөвлөсөн байна.

Суурь зарлагад тооцсон хөрөнгийн зардал /сая төг/

Нэр төрөл	Сангийн яам	ИТХ-ын тогтоол	Нэмэгдсэн дүн
Орон нутгийн хөрөнгө оруулалт	2,564.2	5,594.2	3,030.0
Замын сан	0	624.0	624.0
нийт дүн /сая төг/	2,564.2	6,218.2	3,654.0

Аймгийн ИТХ-аар 2018 оны төсвийн суурь орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 3,682.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн ба орлого нэмснээс үүссэн зөрүү/ашиг/-г “орон нутгийн хөрөнгө оруулалт” нэрээр суурь зарлагыг нэмэгдүүлэн баталсан. Энэхүү суурь зарлагад тооцсон хөрөнгийн зардал нь Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 6.1-д заасан **орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардалд** тавигдах шаардлагыг хангахгүй байна. Үүнд:

- 6.1.1. өөрийн хэрэгцээнд албан конторын барилга худалдаж авах эсхүл шинээр барих
- 6.1.2. шинээр барих барилгын зураг төсөв, техникийн бусад зөвшөөрөл
- 6.1.3. их засвар хийхээр бол холбогдох төсвийг зохих норм, норматив, дүрмийн дагуу бэлтгэсэн байх
- 6.1.4. тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авахаар бол өртгөө бүрэн нөхсөн эсвэл бүртгэлээс хасагдсаныг нотолсон байх
- 6.1.5. албан ажлын хэрэгцээнд уналгын автомашин өөрийн хөрөнгөөр худалдаж авах аар бол үнийн саналын судалгааг бэлтгэх.

Гэтэл суурь зарлагад багтсан **орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардалд** “автозам, барилга, их засвар, дэд бүтэц, гэрэлтүүлэг, тохижилт, хилийн цэрэг, хууль хүчний байгууллагуудад олгох хөрөнгийн дэмжлэг” зэрэг дээрх Засгийн газрын тогтоолын 6.1-т заасан шаардлагыг огт хангахгүй төсөл, арга хэмжээ ихээр орсон байна. (эх сурвалж: аймгийн ИТХ-ын 2017.12.01-ний 06/02 тогтоол)

Орон нутгийн төсвийн суурь зарлагад багтсан хөрөнгийн зардлын 3,788.1 сая төгрөг буюу 68 хувь нь орон нутгийн /аймгийн/ удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй байгаа бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарч байна. Дэлгэрэнгүйг аудитын тайлангийн хавсралт 1-т харуулав.

Өөрөөр хэлбэл Төсвийн тухай хуулийн 58.2.1-т заасан “аймгийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардал”-ыг Төсвийн тухай хуулийн 58.2.2 - 58.2.16-д заасан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүргүүдийг төлөвлөн батлуулжээ.

Төсвийн тухай хуулийн 58.2.2 - 58.2.16 дахь чиг үүргүүдийг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.2-т дэлгэрэнгүй зааж өгсөн. Тухайлбал их засвар, автозам, барилга, дэд бүтэц, гэрэлтүүлэг, тохижилтын ажил гэх мэт ажлууд нь бүгд хөгжлийн сангийн чиг үүрэгт хамаарахаар байна.

Үүнээс гадна орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн Цагдаагийн пост барих, Хилийн цэргийн ангиудад худаг гаргах, харуулын байр барих зэрэг ажлууд нь Төсвийн тухай хуулийн 58.2.1-т заасан аймагийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй байна. Эдгээр чиг үүргүүд нь тухайн салбарын /хуульзүй, дотоод хэргийн яамны/ төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүрэгт хамаарах бөгөөд “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 1.2.3-т заасан **орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардалд** хамаарахгүй болно. Өөрөөр хэлбэл “орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал”-д аймаг, сумын ИТХ, ЗДТГ, Баг болон Засаг даргын шууд харьяанд байгаа орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардал хамрагдана.

Замын-Үүд сумын ИТХ-аар сумын төсвийн хөрөнгө оруулалтад 327.5 сая төгрөгийн хөрөнгийн зардал баталсан бөгөөд үүнд орон нутгийн хөгжлийн сангийн чиг үүрэгт хамаарах 232.6 сая төгрөгийн зардал мөн багтсан байна. /хавсралт 2/

Бүлэг 2

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний сар улирлын хуваарийг мөрдөж ажиллаагүй байна.

2.1. Орон нутгийн төсвийн 2018 оны нийт орлого ба тусламжийн төлөвлөгөө биелэх бүрэн боломжтой байна.

Аймгийн хэмжээнд жилийн дүнгээр татварын орлого 22,598.5 сая төгрөг, татварын бус орлого 1,297.1 сая төгрөг, тусгай зориулалтын орлогын шилжүүлэг 32,515.2 сая төгрөг, орон нутгийн нэгдсэн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 3,275.6 сая төгрөгийн төлөвлөгөөтэй байна.

2018 оны 3-р улирлын дүнгээр авч татварын орлого 101.3 хувь, татварын бус орлого 144.1 хувь, тусгай зориулалтын орлогын шилжүүлэг 93.2 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 88.4 хувийн гүйцэтгэлтэй байна. /хүснэгт/

2018 оны 3-р улирлын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төг/

Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	17,083.9	17,305.7	221.8	101.3
Татварын бус орлого	1,297.1	1,868.7	571.6	144.1
Тусгай зориулалтын орлогын шилжүүлэг	23,656.7	22,049.9	-1,606.8	93.2
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	2,488.1	2,200.1	-288.0	88.4
нийт дүн /сая төг/	44,525.8	43,424.4	-1,101.4	106.7

Татварын орлогын төлөвлөгөө 101.3 хувиар биелсэн нь Замын-Үүд, Даланжаргалан, Мандах сумын хувь хүний орлогын албан татвар 109-181 хувиар давж биелсэн нь голлон нөлөөлжээ. Бусад сумдын хувьд татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 77-98.9 хувьтай байна.

Татварын бус орлогын төлөвлөгөө 144.1 хувиар биелсэн нь Хөвсгөл, Сайхандулаан, Даланжаргалан, Мандах зэрэг сумдын торгуулийн орлого 306.7 - 6622.3 хувиар давж биелсэнтэй холбоотой байна. Эдгээр сумын торгуулийн орлого 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 0-200.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй байсан ба гүйцэтгэлээр 430.0-12,936.8 мянган төгрөгийн орлого орсон нь төлөвлөгөө өндөр хувиар давж биелэхэд нөлөөлжээ.

Айраг, Дэлгэрэх сумын татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлт 0 хувьтай, Иххэт сум 5.3 хувийн биелэлттэй буюу эдгээр сумдын төлөвлөгөө 94.7-100 хувиар тасарсан байна.

Аймгийн татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлийг 2018 оны жилийн төлөвлөгөөтэй харьцуулбал татварын орлого 77 хувьтай, татварын бус орлого 107.3 хувийн биелэлттэй байна. /хүснэгт/

Татварын болон татварын бус орлогын жилийн төлөвлөгөө
улирлын гүйцэтгэлийг харьцуулсан байдал /сая төг/

Орлогын нэр төрөл	Жилийн төлөвлөгөө	3-р улирлын гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
Татварын орлого	22,598.5	17,305.7	-5,292.8	76.6
Татварын бус орлого	1,741.1	1,868.7	127.6	107.3
нийт дүн /сая төг/	24,339.6	19,174.4	-5,165.2	78.8

Нийтлэг татварын бус орлогын жилийн төлөвлөгөө 3-р улирлын байдлаар 107.3 хувиар биелсэн бөгөөд татварын орлогын жилийн төлөвлөгөөний биелэлт 76.6 хувьтай хэвийн явагдаж байна.

Газрын дуудлага худалдааны орлого 2018 оны 3-р улирлын байдлаар 3,100.0 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 2,623.3 сая төгрөгийн орлого төсөвт төвлөрч, төлөвлөгөө 476.7 сая төгрөгөөр тасарсан байна. Дуудлага худалдаа зохион байгуулах хугацаа болоогүй хүлээгдэж байгаа газруудаас 390.7 сая төгрөгийн төлөвлөсөн орлого нэмж орохоор хүлээгдэж байгаа бөгөөд төлөвлөсөн дуудлага худалдаа бүгд явагдахгүй бол орлого тасрах эрсдэлтэй.

Аймгийн хэмжээнд сумдын ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө жилийн эцэст тасрах магадлалтай байна. Нийт 5 суманд 6 угалз агнах зөвшөөрөл олгогдсоноос 5 угалз агнаж, тэдгээрийн төлбөрт нийт 210.0 сая төгрөг төвлөрөхөөс 131.5 сая төгрөг төвлөрөөд байна. /хүснэгт/

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн
төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төг/

Сумын нэр	жилийн төлөвлөгөө	гүйцэтгэл /2018.09.30/	дутуу
Иххэт	35.0	22.2	-12.8
Мандах	35.0	27.7	-7.3
Өргөн	35.0	27.5	-7.5
Хатанбулаг	70.0	26.9	-43.1
Эрдэнэ	35.0	27.2	-7.8
нийт дүн	210.0	131.5	-78.5

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг Засгийн газрын 2017 оны 339 дүгээр тогтоолын дагуу /6 угалз*14000 ам.доллар*2500 төгрөг/ тооцон нийт 210.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хураамж нь ан агнасны төлбөр 11,200 ам доллар болон улсын тэмдэгтийн хураамж 2800 ам доллараас бүрддэг байна. Ан

амьтны нөөц ашигласны төлбөрийг төлөвлөхдөө улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг хамтад нь ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнд тусгажээ.

БОАЖЯамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу улсын тэмдэгтийн хураамж нь сумын төсөвт орохгүй, зөвшөөрөл олгож буй байгууллагын харьяа татварын албанд төвлөрөхөөр болсон байна. Үүний улмаас сумдын ан амьтны нөөц ашигласны төлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан улсын тэмдэгтийн хураамжийн орлого тасрах нөхцөл үүсчээ.

Улсын тэмдэгтийн хураамж сумын төсөвт төвлөрөхгүй болсноос шалтгаалсан 35.0 сая төгрөгийн, нэг угалз агнаагүй тул төлбөрийн дутуу 35.0 сая төгрөг нийт 70.0 сая төгрөгөөр уг орлогын төлөвлөгөө тасрахаар байна.

Гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулсан ан амьтны төлбөр, хураамжийн орлогоос сумын төсөвт орох улсын тэмдэгтийн хураамжийг БОАЖЯамны хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын даргын 2018 оны 06/1122, Татварын ерөнхий газрын татварын орлогын газрын даргын 2018 оны 04/650 тоот албан бичгийн дагуу **Чингэлтэй дүүргийн орон нутгийн төсвийн татварын орлогын дансанд төвлөрүүлэхээр** болсон байна.

Дээрх албан бичигт дурдсанаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42.1, 43.1-т заасны дагуу “тэмдэгтийн хураамжийг үйлчилгээ үзүүлэгч эрх бүхий байгууллага нь хураан авч харьяалах татварын албанд тайланг гаргаж өгнө” гэсэн заалтыг мөрдлөг болгосон байна.

Орлогыг буцаан хуваарилах эсвэл хуульд заасан тэмдэгтийн хураамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь аймгуудын БОАЖГазар байх боломжтой эсэхийг судлах нь зүйтэй байна.

2.2. Төсөвт байгууллагууд Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалд заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын 30 хувийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого:

Аймгийн хэмжээнд 2018 онд нийт 1,074.8 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг 13 сан, 19 байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэхээр тооцож төлөвлөсөн байна. Үүнд:

- аймгийн театр, сумдын соёлын төвүүд 58.9 сая төгрөг;
- аймгийн ОНӨГ, БТСГ, ХГБЗХХэлтэс 26.0 сая төгрөг;
- 4 сумын нөхөн сэргээлтийн сан 49.2 сая төгрөг;
- 9 сумын сум хөгжүүлэх сан 940.7 сая төгрөгийн орлого олохоор тус тус тооцжээ.

Үндсэн үйл ажиллагааны нийт орлогын 87.5 хувийг сум хөгжүүлэх сан, 4.6 хувийг нөхөн сэргээлтийн сан, 7.9 хувийг төсөвт байгууллагууд эзэлж байна.

Мөн аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд туслах үйл ажиллагааны орлогоос нийт 345.3 сая төгрөгийн олохоор төлөвлөсөн байна. Үүнд:

- сумдын ЗДТГазар 29.4 сая төгрөг;
- 6 сумын нөхөн сэргээлтийн сан 71.4 сая төгрөг;
- 3 сумын сум хөгжүүлэх сан 210.9 сая төгрөг;
- замын сан 30.0 сая төгрөг;
- байгаль орчны газар 3.5 сая төгрөгийн орлого тус тус олохоор тооцжээ.

Туслах үйл ажиллагааны орлогын 90.4 хувийг сангуудын орлого, 9.6 хувийг сумдын ЗДТГ, аймгийн Байгаль орчны газрын орлогоос бүрдүүлэхээр тооцсон байна.

Сумдын санхүүгийн алба сум хөгжүүлэх сан болон нөхөн сэргээлтийн сангуудын орлогыг өөр өөр орлогын ангилалд буюу үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын нэр төрөлд харилцан адилгүй төлөвлөсөн байна. Мөн ихэнх сумд зээлийн эргэн төлөлтийн орлого, хүүгийн орлогыг салгаж төлөвлөлгүй нийт дүнгээр төлөвлөсөн байв.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого:

Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 7.7-д “**үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын 30 хувийг тухайн байгууллага төсөвт төвлөрүүлнэ**” гэж заасан байдаг. Үүний дагуу шалгаж үзэхэд дараах байдалтай байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар нийт 389.3 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого олсон гэж тайлагнасан байна. Үүний 30 хувь буюу 116.8 сая төгрөгийг дээрх журмын заалтын дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ёстой боловч зарим байгууллага нэмэлт дансаар авсан түрээсийн орлогын 50 хувийг төвлөрүүлснээс өөр орлого төвлөрүүлээгүй байна.

Аудитын явцад дээрх 389.3 сая төгрөгийн нэмэлт орлогыг шалгаж үзэхэд 131.8 сая төгрөгийн орлого нь үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого биш байв. Тухайлбал:

- Замын-Үүд сумын Борхойн наран өрхийн эрүүл мэндийн төв харилцах дансны үлдэгдэл 17.5 сая төгрөгийг данс андуурч шивсэн;
- Замын-Үүд сумын ЗДТГазар дээд шатны байгууллагаас олгосон болон Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон дэмжлэг зэрэг төсвийн санхүүжилтийн 35.6 сая төгрөг;
- Замын-Үүд сумын ИТХ олон нийтийн цагдаагийн урамшуулал 3.3 сая төгрөг, 5-р цэцэрлэг сумын хөрөнгө оруулалтаар өгсөн 5.8 сая төгрөг, 1-р сургууль 3.7 сая төгрөгийн төсөл хөтөлбөрийн санхүүжилт;
- Айраг сумын ЗДТГазар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандивын орлого 10.5 сая төгрөг;

- Өмнөх оны нэмэлт дансны үлдэгдлийг буцаан олгосон санхүүжилт Мандах сумын ЗДТГазар 11.0 сая төгрөг, Сайншанд сумын ЗДТГазар 9.1 сая төгрөг, Даланжаргалан сумын ЕБС 1.7 сая төгрөг, аймгийн ГХБХБГазар 8.3 сая төгрөг, аймгийн ЗДТГазар 19.6 сая төгрөг;
- Сайншанд сумын ЗДТГазар олон нийтийн цагдаагийн урамшуулал 2.3 сая төгрөг, Зүүнбаян багийн алба шүлхийний санхүүжилт 3.4 сая төгрөгийг тус тус үндсэн үйл ажиллагаанаас олсон нэмэлт орлого гэж тайлагнасан байна.

Үндсэн үйл ажиллагаанаас олсон нэмэлт орлогыг зарцуулахаар аймгийн СТСХ-т ирүүлсэн баримт материалыг шалгаж үзэхэд Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан журмын 5.3-т заасан баримт, материалыг бүрэн бүрдүүлж ирүүлсэн байгууллага байхгүй байна.

Журмын дагуу зарлагын хэмнэлт, нэмэлт орлогын тайланг 1,2 дугаар хавсралт маягтаар гаргах, зохион байгуулсан ажил, хүрсэн үр дүнгийн тухай танилцуулга, орлогыг зарцуулах тухай хамт олны хурлын тэмдэглэл, шийдвэр, бусад нотлох баримт зэргийг ирүүлэх ёстой. Гэтэл төсөвт байгууллагууд нэмэлт орлого олсон тухай материалыг бүрдүүлж ирүүлэхийн оронд Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлтийн маягт, албан тоот, дансны хуулга зэргийг ирүүлж нэмэлт орлогыг зарцуулах эрхээ нээлгэдэг байна.

Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.1-т заасны дагуу **үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод дараах орлогыг тооцно** гэж заасан. Үүнд:

- 3.1.1. Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хагас жил эсвэл жилийн төлөвлөгөөнөөс давсан хэсэг
- 3.1.2. Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд тухайн жилд шинээр бий болгосон “нэмэлт орлого”
- 3.1.3. Төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон ашиг

Гэтэл төсөвт байгууллагуудын олж буй нэмэлт орлогууд нь дээрх шалгуурыг хангаж чадахгүй байна. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт сул байгаагаас шалтгаалж төсөвт байгууллагууд хууль тогтоомжийн дагуу олж буй орлогыг нэмэлт төсвийн дансанд жил бүр төвлөрүүлэн зарцуулах, жил дараалан тогтмол олж буй орлогыг төсвийн төлөвлөгөөнд тусгахгүйгээр нэмэлт дансанд авч зарцуулах, төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт орлого олох зэрэг зөрчлүүдийг гаргаж байна. Тухайлбал:

- Аймгийн ЗДТГазар Архивын тухай хуулийн 25.4, Архивын ерөнхий газрын даргын 2015 оны А/168 дугаар тушаалын дагуу олж буй архивын үйлчилгээний хөлс, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйл, ЗГ-ын 2016 оны 215 дугаар тушаалын дагуу авч буй цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийг тус тус нэмэлт төсвийн дансанд төвлөрүүлж үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор тайлагнан зарцуулж байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.3-т заасан “хуулиар төсөвт төвлөрүүлэхээр тусгайлан заасан орлого нь аливаа байгууллагын үйл ажиллагааны орлогод тооцогдохгүй”, 3.5.4-т “Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй байхыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

- Мөн аймгийн ЗДТГ, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж техник, хяналтын орлогыг төсвийн төлөвлөгөөнд тусгахгүйгээр жил бүр нэмэлт төсвийн дансаар дамжуулан зарцуулж байна. Дээрх журмын заалтууд мөн адил зөрчигдөж байна. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2017.05.04-ны 1/788 тоот албан бичигт “улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй техник, хяналтын орлого нь Төсвийн тухай хуулиар улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдаж байгаа бөгөөд зардлыг байгууллагын төсөвт тусган зарцуулагдаж байна” гэсэн байна.
- Сумдын ЗДТГ нь өвс тэжээлийг худалдан авч иргэдэд борлуулах замаар 2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 90.8 сая төгрөгийн нэмэлт орлого олсон байна. Өвс тэжээлийг иргэдэд худалдан борлуулж, нэмэлт орлого олж болох талаар ТЕЗ-ийн зөвшөөрсөн албан бичиг байхгүй байгаа нь дээрх журмын 1.3.1-т заасан “нэмэлт орлого олох үйл ажиллагааг Төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх” гэсэн заалтыг зөрчиж байна.
- Мөн сумдын ЗДТГазар жил бүр тогтмол олж буй төрийн өмчийн орон сууцны түрээс, тендерийн хураамжийн орлого, сумдын Захирагчийн ажлын алба гудамжны самбарын түрээсийн орлого, захиалагчийн техник хяналтын орлого зэргийг төлөвлөхгүйгээр нэмэлт төсвийн дансаар дамжуулан жил бүр захиран зарцуулж байна.

Төсөвт байгууллагууд орлогын төлөвлөгөөнд тусгагдаагүй олсон орлого бүрийг нэмэлт төсвийн дансаар дамжуулан зарцуулах хандлага бий болсон байна.

Төсөвт байгууллагуудын нэмэлт төсвийн жилийн эцсийн үлдэгдлийг буцаан олгож, хоёр төсвийн жил дамжуулан зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 43.1, 43.5 дахь заалтыг зөрчиж байна.

Төсвийн тухай хуулийн 43.1-т “ЗГ-ын өрийн бичиг, зээлийн төлбөр, ЗГ-ын гэрээгээр болон олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөв, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан тусламж, хандив”-ын дансны үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжүүлэн зарцуулж болно, мөн хуулийн 43.5-д “дээрх 43.1-т зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэж заасан.

Төсөвт байгууллагуудын нэмэлт орлогын бүрдүүлэлт, тайлагнах үйл явц, жилийн эцсийн дансны үлдэгдлийг буцаан олгоход тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.3. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг төвлөрүүлээгүй бөгөөд сумын төсвөөс аймагт төвлөрүүлэх хөрөнгийг хуулийн дагуу хуваарилаагүй байна.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар Дорноговь аймгийн төсвөөс 2,124.1 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр тусгасан байна.

Сангийн сайдын 2017 оны 388 дугаар тушаалаар баталсан сар улирлын хуваарийн дагуу 2018 оны 1, 2, 3 дугаар улиралд нийт 1,876.1 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэхээр баталсан боловч 3-р улирлын байдлаар улсын төсөвт орлого огт төвлөрүүлээгүй байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41.2-т заасан "бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ. Үүнд 41.2.1. хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах ... орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг биелүүлээгүй буюу хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12-р сарын 01-ны 06/02 тогтоолоор Замын-Үүд сумын төсвөөс аймгийн төсөвт 3,061.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр тусгасан. Үүний дагуу 2018 оны 3-р улирлын төсвийн сар улирлын хуваарийн дагуу 2,450.0 сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлжээ.

Замын-Үүд сумын төсвөөс аймгийн төсөвт орлого төвлөрүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.2 дахь заалтыг баримтлаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.2-т “доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас их тохиолдолд суурь зарлагатай тэнцэх хэсгийн ... 40 хувийг 2018 оны төсвийн жилд ... тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ” гэж заасан. Хуулийн дагуу хуваарилбал зохих байсан дүнг хүснэгтэд харьцуулан харуулав.

Замын-Үүд сумын төсвийн үндсэн тэнцлийн ашгаас
дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого /сая төг/

Үзүүлэлт	Сумын ИТХ-ын тогтоолоор баталсан дүн:	Төсвийн тухай хуулийн дагуу хуваарилах дүн
Суурь орлого:	4,821.7	4,821.7
Суурь зарлага:	1,760.1	1,760.1
Суурь орлого, зарлагын зөрүү буюу тэнцлийн ашиг	3,061.6	3,061.6
Үүнээс:		

дээд шатны төсөвт буюу аймагт төвлөрүүлэх дүн	3,061.6	1,837.0
тухайн шатны төсөвт буюу сумын төсөвт үлдэх дүн	0.0	1,224.6

Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн төсөвт 1,836.9 сая төгрөгийг татан төвлөрүүлж, Замын-Үүд сумын төсөвт 1,224.6 сая төгрөгийг үлдээж хуваарилах байв.

Бүлэг 3

Төсвийн тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй байна

3.1 Хэмнэгдсэн зардлын дийлэнх хувийг төсвийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл эзэлж байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.11-д “Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-оос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухайн сумын ИТХ тогтооно” гэж заасныг үндэслэн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор дийлэнх сумдад сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуй нэгжид зээл олгоогүй, өмнөх онд олгосон зээлийн төлөлт орж ирсэн зэргээс шалтгаалж 2018 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар дараах 8 суманд 1071.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Хүснэгт 1. Сум хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл

Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт
Айраг	155,000,000	36,000	(154,964,000)
Даланжаргалан	172,790,400	-	(172,790,400)
Дэлгэрэх	97,694,000	-	(97,694,000)
Мандах	167,063,700	110,000,000	(57,063,700)
Сайхандулаан	133,747,000	60,000,000	(73,747,000)
Улаанбадрах	121,000,000	23,500,000	(97,500,000)
Хатанбулаг	107,000,000	-	(107,000,000)
Сайншанд төв сум	313,000,000	1,581,033	(310,668,967)
Дүн	1,267,295,100	195,117,033	(1,071,428,067)

Төрийн сангийн программд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн өмнөх оны үлдэгдэл болон тайлант оны төсвийн хуваарийг шивж оруулаагүйгээс Айраг сум 15.1 сая төгрөг, Даланжаргалан сум 38.7 сая төгрөг, Мандах сум 23.7 сая төгрөг, Замын-Үүд сум 18.3 сая төгрөг нийт 95.7 сая төгрөгөөр ОНХС-ийн төсөв хэтэрсэн мэт харагдаж байна.

Замын-Үүд сумын тусгай шилжүүлгийн зарим байгууллагуудын тогтмол зардал 2018 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 107.9 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Тухайлбал: Сумын нэг, тавдугаар цэцэрлэг тогтмол зардлын нийт дүнгээрээ 42.5 сая төгрөгийн хэмнэлттэй бөгөөд үүний 16 хувь буюу 6.8 сая төгрөг нь өмнөх онд дээрх зардлыг илүү шилжүүлэн авлага үүсгэн бүртгэснээс, үлдэх 35.7 сая төгрөг нь 6-9 саруудад тогтмол зардал хуваарилагдаагүйгээс үүссэн, өөрөөр хэлбэл 4 дүгээр улиралд гарах тогтмол зардлын дүн байна.

Мөн сумын 2 дугаар сургуулийн тогтмол зардал нийт 29.3 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа нь 2017 оны жилийн эцэст зардлыг илүү шилжүүлэн авлага үүсгэн бүртгэснээс үүсжээ.

Аймгийн ИТХ-ын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь 96.9 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Энэ нь аймгийн ИТХ-ын Төлөөлөгчид тойрогтоо хөрөнгө зарцуулах журмын дагуу хурлын хороод болон төлөөлөгчдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөлд дэмжлэг болгоход олгох зорилготой хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

БОАЖГ-ын цалин хөлс, урамшлын зардал 21.7 сая төгрөгийн, бараа ажил үйлчилгээний бусад зардал 66.2 сая төгрөгийн буюу нийт 87.9 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Тус байгууллагын даргын 2018 оны 1 дүгээр сарын А/01 тоот тушаалаар бүтцийг 18 хүний орон тоотойгоор баталсан бөгөөд одоогийн байдлаар 15 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж 3 хүний ажлын байр сул байна. Ажлын байрны орон тоо дутуу байгаагаас шалтгаалан 3 хүний цалин 14.4 сая төгрөгөөр хэмнэгджээ. Мөн байгаль хамгаалах нөхөн сэргээх сангийн үлдэгдэл 66.2 сая төгрөг байгаа нь булаг шанд тохижуулах, засварлах, байгаль хамгаалах нөхөн сэргээх зарим ажлууд хийгдэж дуусаагүй байгаагаас шалтгаалсан байна.

3.2. Батлагдсан төсөл арга хэмжээний нэр, төсөвт өртгийг өөрчлөн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн нь холбогдох хуулийг зөрчсөн байна. Монгол улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар тус аймагт 5 сайдын багцын хүрээнд барилга байгууламж 10, их засварын ажил 2 нийт 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 49,074.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан байна. Үүнд:

2018 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан ТАХ /сая.төг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	Барилга байгууламж			Их засвар			Нийт		
	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн
БХБСайд	3	12,072.5	1,733.0	1	1,600.0	300.0	4	13,672.5	2,033.0
БСШУСС айд	3	4,900.0	2,350.0	1	142.2	100.0	4	5,042.2	2,450.0
ЗТХСайд	1	16,335.0	1,271.9				1	16,335.0	1,271.9
ХНХСайд	1	3,200.0	1,000.0				1	3,200.0	1,000.0

ХХААХҮС айд	1	7,300.0	1,200.0				1	7,300.0	1,200.0
ЭМСайд	1	3,524.4	850.0				1	3,524.4	850.0
ДҮН	10	47,331.9	8,404.9	2	1,742.2	400.0	12	49,074.1	8,804.9

Нийт төсөл арга хэмжээний 29,759.5 сая төгрөг буюу 88.7 хувь нь 2011 оноос эхлэн хэрэгжиж байгаа, 11.3 хувь нь шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт байна. Үүнээс аймгийн Засаг даргад 38,401.7 сая төгрөгийн 8 ТАХ-ний эрх шилжиж ирсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.4¹ дэх заалтын дагуу аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын хурлаар 2018 онд шинээр 5,941.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27, өмнөх оноос дамжин хэрэгжих 5,361.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10, замын сангийн хөрөнгөөр 915.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 буюу нийт 12,217.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 06/02 тогтоолоор батлагдсан ТАХ /сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн /сая.төг/
1	Барилга байгууламж	23	5,740.4
2	Их засвар	2	860.0
3	Машин, тоног төхөөрөмж	5	157.0
4	ТЭЗҮ, зураг төсөл	2	98.0
5	Өмнөх оноос шилжих	10	5,362.1
	Нийт дүн	42	12,217.5

Замын-Үүд сумын ИТХ-аар 2018 оны сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 12 төсөл арга хэмжээнд 327.5 сая төгрөг баталсан байна.

Аймгийн ИТХ-аар 2018 онд хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ-ний төсөвт өртгийг нэмэгдүүлэн эрх шилжүүлэх, жагсаалтаар батлагдсан болон хавсралтад тусгагдсан санхүүжилтийн дүнгүүд хоорондоо зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

- Аймгийн ИТХ-ын 2017 оны 06/02 тогтоолоор Сайншанд хот тохижилтын газрын автомашины гражийн барилгыг 48.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд Засаг даргын 2018 оны А/665 дугаар бүхий захирамжаар уг ажлын төсөвт өртөгт 129.5 сая төгрөгийг нэмж нийт 177.5 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэхээр эрх шилжүүлсэн байна.
- Аймгийн ИТХ-ын 2017 оны 06/02 тогтоолоор 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын 5594.2 сая төгрөгийн ТАХ-ний жагсаалтыг гаргасан байтал тогтоолын 5 дугаар хэсэгт хөрөнгө оруулалтын зардлын хэмжээг 5,671.9 сая төгрөгөөр баталсан нь 77.7 сая төгрөгөөр зөрж байгаа бөгөөд энэ талаар тайлбар ирүүлээгүй болно. Энэ нь хэдэн ТАХ-г 77.7 сая төгрөгөөр санхүүжүүлэх нь тодорхойгүй байна.

¹. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор батлах;

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь аймгийн Засаг даргаар, Замын-үүд сумын ЗАА нь сумын Засаг даргаар 2018 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг тус тус батлуулан ТБОНӨХБАҮХАХТ хуулийн 48.5²-д заасны дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайтад байршуулж нийтэлсэн байна.

Аймгийн ОНӨГ-аас 2018 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 81.9 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 0.6 хувийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар, 2.3 хувийг харьцуулалтын аргаар, 15.2 хувийг шууд гэрээ байгуулах аргаар тус тус зохион байгуулжээ.

Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт эрх шилжиж ирсэн 12 ТАХ-ээс 10 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг аймгийн ОНӨГ-аас зохион байгуулсан байна. 2018 оны 3-р улирлын байдлаар тендерт шалгарсан компаниуд 1,982.5 сая төгрөгийн 6 ТАХ-г гэрээний хугацаанд дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгсөн ба 8,248.1 сая төгрөгийн 4 ТАХ-ний гэрээний хугацаа дуусаагүй байна.

Аймгийн ОНӨГ болон Замын-Үүд сумын ЗАА-наас сумын ИТХ-аар батлагдсан болон орон нутагт эрх шилжиж ирсэн ажлын батлагдсан нэр, зориулалтыг өөрчлөн ХАА-г зохион байгуулсан нь Сангийн сайдын 2016 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.21³ дэх заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2017 оны 12 сарын 07-ны өдрийн 07/07 тоот тогтоолоор 2018 онд хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын ТАХ-нд 2018 оны 3 дугаар сарын 08/01 тогтоолоор өөрчлөлт оруулсан байна. Үүнд:
 - Төв талбайд орон нутгийн онцлогийг харуулсан цамхагтай цагийг төв цэгт байршуулах 30.0 сая төгрөг
 - Сүлд багийн 11 дүгээр хэсгийн Замчдын гудамжны авто замын ажлыг гүйцэтгэх 20.0 сая төгрөг
 - 2018, 2019 онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлын зураг төсөв боловсруулах 50.0 сая төгрөг

Эдгээр 100.0 сая төгрөгийн 3 ТАХ-г хасаж Гадаадын иргэн харьяатын Дорноговь аймаг дахь газарт суудлын автомашин нийлүүлэхэд 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг нэмж өөрчлөн оруулжээ. Замын-Үүд сумын Засаг даргын 2018 оны 5 дугаар сарын А/150 дугаар захирамжаар хөрөнгө оруулалтын зардлаас 98.0 сая төгрөгийг нэмж нийт 198.0 сая төгрөгөөр автомашиныг авсан байна. ИТХ-ын тогтоол шийдвэргүйгээр 98.0 сая төгрөгийг дур мэдэн хөрөнгө оруулалтын зардлаар санхүүжүүлсэн байна.

². Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ;

³. Батлагдсан нэр, байршлыг солих, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно;

- 2018 оны Төсвийн тухай хуулийн XII.2.13-д тусгагдан БХБСайдын багцаас эрх шилжиж ирсэн “Иххэт сумын нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар” гэж батлагдсан нэр, зориулалтыг “Төвийн болон орон сууцны шугам сүлжээний засвар, уурын зуухны засвар” гэсэн нэрээр өөрчилж нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 3 багц болгон ХАА-г зохион байгуулжээ. Дээрх ажил 1,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2018 оны Төсвийн тухай хуулиар 2018 онд 300.0 сая төгрөгийг, 2019 онд 1300.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тус тус батлагджээ.

Багц 1-т зарлагдсан 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дээврийн засварын ажлыг Бэмэс ХХК гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Улсын төсвөөс 134.5 сая төгрөгийн санхүүжилт орж ирснийг Бэмэс ХХК-д олгосон бөгөөд энэ оны батлагдсан төсвөөс 165.5 сая төгрөгийн санхүүжилт 2018 оны 10 дугаар сарын 2-ний өдрийн байдлаар орж ирээгүй байна.

Харин 2018 онд санхүүжилтийн эх үүсвэр байхгүй байхад 2,3 дугаар багцаар зарлагдсан уурын зуухны засвар, төвийн болон орон сууцны шугам сүлжээний засварын ажлыг аймгийн Чандмань-Илч ХХК-ийн 889.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна.

Мөн ХНХСайдын болон БСШУССайдын багцад хуваарилагдсан 3,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн барилга, 1,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 150 ортой Цэцэрлэгийн барилга угсралтын ажлын ХАА-г зохион байгуулах эрхийг орон нутагт шилжүүлсэн байна.

Аймгийн ОНӨГ-аас Цэцэрлэгийн барилгын тендерийн урилгыг 2018 оны 9 дүгээр сарын 25-нд нийтэлж, 30 хоногийн хугацаатай, мөн Иргэдийн хөгжлийн төвийн барилгын тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлсэн бөгөөд тендерийг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр нээх хугацаатай байна.

Дээрх 2 ТАХ-г ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу орон нутагт зохион байгуулах эрхийг салбар яамдаас 2018 оны 1, 2 дугаар сард шилжүүлсэн боловч хугацаа алдаж оны эцэст тендерийг зарлаж байгаа нь дээрх хуулийн 48.5⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

3.3 Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар улсын төсвийн байгууллагад 9 төсөл арга хэмжээг 1,896.6 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтыг төлөвлөн

⁴.Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд зарлан мэдээлнэ;

баталсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁵, 4.1.27⁶, 6.6.6⁷ дэх заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Хилийн цэргийн 0129 дүгээр ангид Хилийн харуулын байр 30.0 сая төгрөг
- Хилийн цэргийн 0108 дугаар ангид гүний худаг 32.0 сая төгрөг
- Хилийн цэргийн 0168 дугаар ангид Харуулын байр 30.0 сая төгрөг
- Эрдэнэ суманд Цагдаагийн постын барилга 57.1 сая төгрөг
- Сайншанд 4 дүгээр баг Эмнэлгийн барилга 1522.6 сая төгрөг
- Замын-Үүд сумын ШШХэсгийн конторын барилгын засварт 3.4 сая төгрөг
- Замын-Үүд сумын Цагдаагийн хэлтэст гэрч, хохирогчийн хамгаалах өрөөний засварт 7.0 сая төгрөг
- Хилийн мэргэжлийн хяналтын албанд Лабораторийн тоног төхөөрөмж 16.5 сая төгрөг
- ГИХГазарт суудлын автомашин 198.0 сая төгрөг

Улсын төсвийн байгууллагуудад батлагдсан төсөл арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, зураг төсөв нь батлагдаагүй, техникийн нөхцөл өөрчлөгдсөнөөс тендерийг хүйтний улиралд зарласнаас ажил чанаргүй хийгдэх, төсөвт өртгийг урьдчилан тооцож судлалгүйгээр төсөв батлуулах, худалдан авсан хөрөнгө тухайн байгууллагад оршин байхгүй байгаа зэрэг дараах зөрчлүүд гарсан байна.

Замын-Үүд сумын Хилийн 0108 дугаар ангид 32.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүний 3 худаг шинээр гаргах ажлын эрхийг шилжүүлсэн байна. Тус байгууллагаас 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 16/384 тоот бичигт “гурван худаг гаргах тендерийг 2 удаа зарласан боловч амжилтгүй болсон бөгөөд аймгийн ИТХ-д ажлын тоог өөрчилж өгөхийг хүссэн” талаарх тайлбарыг ирүүлжээ. Уг ажлын явц 30 хувьтай байна.

Сайншанд сумын 4 дүгээр багийн Эмнэлгийн барилгын техникийн нөхцөл өөрчлөгдсөнөөс шалтгаалан тендер шалгаруулалтыг 2018 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс 30 хоногийн хугацаатай зарлагдаж тендерийг 10 дугаар сарын 25-нд нээсэн байна. Хүйтний улирал эхэлж байгаа үед тендерийг зарлан барилгын ажлыг эхлүүлэх нь барилга чанаргүй баригдах эрсдэлийг буй болгож байна.

Дорноговь аймаг дахь ГИХГазарт 198.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй суудлын автомашиныг орон нутгийн хөрөнгөөр худалдан авсан бөгөөд аудитаар тухайн байгууллагад хөрөнгө биетээр оршин байхгүй, эрх бүхий байгууллагын тушаал шийдвэр гараагүй байхад ГИХГазарт хөрөнгийг шилжүүлсэн байна.

⁵.Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

⁶.Орон нутгийн төсөв гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталдсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;

⁷.Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх;

Засгийн газрын 1998 оны 148 дугаар тогтоолоор Төрийн улс төрийн болон төрийн тусгай албыг тодорхой хугацаагаар хашихаар томилогдсон төрийн мэдлийн орон сууцанд суух албан тушаалтны жагсаалтын дагуу манай аймагт албан тушаалын 7 орон сууц байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр төрийн албан хаагч, албан тушаалын 5 орон сууцыг 253.4 сая төгрөгөөр худалдан авсан бөгөөд энэхүү байранд ШШГ-ийн газрын дарга, Онцгой байдлын газрын дарга, Шүүхийн шинжилгээний албаны дарга, 1 дүгээр сургуулийн америк багш, НҮГ-ын дарга нар байрлаж байна. ЗГ-ын 148 дугаар тогтоолоор 8 албан тушаалтны жагсаалт батлагдсан бөгөөд дээрх орон сууцанд байрлах албан тушаал нь тогтоолд заасан жагсаалтад ороогүй байна.

3.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа зарим хөрөнгө оруулалтыг баталсан зураг төсөвгүйгээр гүйцэтгэжээ.

Барилгын төсөв зохиох норм дүрмийн дагуу нэмэгдэл зардлыг тооцохдоо бүсийн ангиллыг буруу тооцсон, барилга байгууламжийн ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэсэн, баталгаажсан зураг төсөлгүй болон анхны зураг төслөөс өөрчлөгдсөн ажилд гүйцэтгэлийн зураг хийлгэж зохиогчоор баталгаажуулалгүйгээр ажлыг гүйцэтгэж байгаа нь Барилгын төсөв зохиох дүрмийн БНБД 81-95-12⁸, Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1.1⁹, 40.1.16¹⁰, 40.1.17¹¹, 40.2¹² дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэж буй Замын-Үүд сумын Соёл, спортын барилга нь 3,084.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2018 онд 600.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Барилгын гүйцэтгэгчээр Гантулга трейд ХХК шалгарсан бөгөөд ажлыг батлагдсан зураг төсөвгүйгээр гүйцэтгэж байна.

Барилгын тухай хуулийн 40.1.16 дахь заалтыг зөрчин барилга байгууламжийг батлагдсан зураг төсөвгүй гүйцэтгэж байгаад аймгийн МХГ-ын улсын байцаагчийн 2018 оны 9 дүгээр сарын 11-07-024/170 албан шаардлагыг тус гүйцэтгэгч компанид хүргүүлсэн байна.

- Орон нутагт эрх шилжиж ирсэн Алтанширээ сумын Соёлын төвийн их засварын ажлыг 137.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр Тольт дэнлүү ХХК шалгарсан байна. Анхны батлагдсан зураг төслөөс өөрчлөлт оруулсан зургийг зохиогчоор баталгаажуулалгүйгээр ажлыг гүйцэтгэсэн байна.
- Замын-Үүд сумын төвийн гудамж, талбайд хяналтын камер суурилуулах ажлыг Бат тод ХХК гүйцэтгэсэн байна. Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-

⁸. Барилгын төсөв зохиох БНБД 81-95-12 дугаартай нормын хавсралт 7-д "Барилгын засварын ажлын нэмэгдэл зардлыг үе шатны ажлын цалингаас, 1 дүгээр бүсэд 69.9 хувиар тооцно. Энэ нормын хавсралт 10-т Сайншанд хот 1 дүгээр бүсэд хамаарна гэж заасан.

⁹. Барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих;

¹⁰. Барилгын ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэхгүй байх;

¹¹. Барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах;

¹². Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

95-12 дагуу нэмэгдэл зардлыг бүгд цалингаас 34.5 хувиар тооцох ёстой байтал 69.9 хувиар тооцон төсөв хийгдсэн байна.

- Улсын төсвийн хөрөнгөөр 1,200.0 сая төгрөгийн өртөгтэй Дэлгэрэх сумын 250 хүний суудалтай Соёл, спортын барилгын ажлыг Евро электроник ХХК гүйцэтгэж байна. Барилгын ажлыг эхлүүлэхдээ эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй, баталгаажсан зураг төсөлгүйгээр ажил хийгдэж байна.

3.5. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлуудад барилга хөгжлийн төвөөс захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт эрх шилжиж ирсэн 38,401.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 8 ТАХ, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 3,996.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 17 ТАХ-д аймгийн ЗДТГазар болон ГХБХБГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46-р зүйлийн Захиалагчийн эрх, үүргийн 46.1.6 дахь заалтад “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, БХБС-ын 2015 оны “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 2.2¹³, 2.10¹⁴ дахь заалтын дагуу захиалагч болон зохиогчийн хяналтыг дараах ажлуудад бүрэн хэрэгжүүлээгүй байна.

- Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар Бат тод ХХК-ний гүйцэтгэсэн сумын Цагдаагийн газарт ашиглагдаж байгаа 41 камернаас 21 камер байнгын хэвийн ажиллагаатай, үлдэх 20 камер нь хэвийн бус, үйл ажиллагаа нь доголдолтой, зарим камерийн дэлгэц огт асахгүй байхад захиалагч байгууллагаас хяналт тавиагүй, ажлыг хүлээлгэн өгсөн байна. Аудитаар ажиллахгүй байгаа камерийг гүйцэтгэгч байгууллагаар засуулах албан шаардлага өгөв.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж буй Замын-Үүд сумын Соёл, спортын барилгад Барилга хөгжлийн төвөөс захиалагчийн хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна.
- Иххэт сумын нийтийн орон сууцнуудын гадна дулаан, цэвэр усны шугамын угсралтын ажлын зохиогчийн хяналтын гэрээг Хайдродизайн прожект ХХК-тай байгуулжээ. Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээнд инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын явцад 3 удаа, ажлыг ашиглалтад хүлээн авах үед 2 удаа буюу нийт 5 удаа хэрэгжүүлэхээр тусгагдсан боловч зохиогчийн талаас хяналтыг 3 удаа хэрэгжүүлж ажиллажээ.
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа Дэлгэрэх сумын Соёл, спортын цогцолбор барилгыг Евроэлектроник ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 20-нд ажлыг хүлээлгэн өгөхөөр гэрээнд заажээ.

¹³.Зураг төсөл зохиогчийн хяналтыг барилгын ажилд байнгын, барилгын ажилд хуваарийн дагуу тогтмол, барилгын ажлын тодорхой үе шатуудад хяналт тавих;

¹⁴. зураг төсөл зохиогчийн хяналтын дүгнэлтэд зөрчил дутагдлыг арилгах талаар заавар зөвлөмжийг өгч, хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр нь арилгаж, хэрэгжилтийг хангасан тухай захиалагч, гүйцэтгэгчээс биелэлтийг гаргуулна.

Аудитаар 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр барилгын үйл ажиллагаатай танилцахад суурийн ажил хийгдэж дууссан байсан бөгөөд хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй, талбайн журнал, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тэмдэглэл зэргийг холбогдох дүрэм, зааврын дагуу бүртгэж хөтлөөгүй, Барилга хөгжлийн төвөөс захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Барилгын тухай хуулийн 40.1.16 дахь заалт, барилга байгууламжийн зарим ажлыг барилгын норм дүрэм, стандартын дагуу гүйцэтгээгүй, хүйтний улирал эхэлж байгаатай холбоотойгоор гадна агаарын хэм хасах 5-д хүрсэн тохиолдолд барилга угсралтын бетон хийц цутгах, өргийн ажлыг гүйцэтгэхгүй байх зэрэг асуудлаар аймгийн ГХБХБГ-аас 2018 оны 10 дугаар сарын №886 дугаар бүхий албан шаардлагыг гүйцэтгэгч компанид, мөн №910 дугаар бүхий албан бичгийг Барилгын хөгжлийн төвд тус тус хүргүүлжээ.

- Сайншанд суманд баригдаж буй 320 хүүхдийн Сургуулийн барилгад зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн боловч зохиогчийн хяналтын тайланг холбогдох маягт зааврын дагуу гаргаж ирүүлээгүй байна.

Улсын төсвөөс санхүүжигдэн гүйцэтгэж байгаа барилга байгууламжид захиалагч, зохиогчийн гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа зарим төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл чанаргүй, норм стандартын дагуу ажлыг дутуу гүйцэтгэх зэрэг нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

3.6. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж ашиглалтад хүлээлгэн өгсөн 5 төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгуулав.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 368.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байсныг аудитын явцад данс бүртгэлд тусгууллаа. Үүнд:

- Дорноговь аймаг дахь ГИХГ-т нийлүүлэгдсэн 198.0 сая төгрөгийн суудлын автомашин
- Замын-Үүд Хот тохижилтийн газарт хүлээлгэн өгсөн 92.8 сая төгрөгийн Хог зөөврийн автомашин, 22.7 сая төгрөгийн өртөгтэй 10 ширхэг Хогийн бункер
- Хилийн мэргэжлийн хяналтын газар 16.1 сая төгрөгийн Лабораторийн багаж
- Замын-Үүд суманд суурилуулсан Хяналтын камер 38.9 сая төгрөг

**Бүлэг
4**

Аймаг, сумын ИТХ-аас төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшинг батлаагүйгээс хүрэх үр дүнг хэмжих үзүүлэлт байхгүй байна.

4.1. ТЕЗ-ийн хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг боловсруулахад баримтлах шалгуур үзүүлэлт, заавар, журам байхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар батална” гэж заасан.

Мөн Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.5.6, 7.6.5-д “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж, төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулж, дараахь зүйлийг тусгана” гэж заасан. Үүнд:

- а/ төсвийн захирагчийн нэр
- б/ хөтөлбөрийн нэр
- в/ тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт
- г/ тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт
- д/ зарцуулах төсөв

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний 06/02 тогтоолоор “Дорноговь аймгийн 2018 оны төсвийг батлах”-даа аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, зориулалт, зарцуулах төсвийн мөнгөн дүнг баталсан боловч хөтөлбөрийн хүрэх үр дүн, чанарын болон тоон үзүүлэлтийг тусгаагүй байна.

Сумдын ИТХ-ын тогтоолыг авч үзэхэд 6 сум хөтөлбөр, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг батлаагүй, 5 сум хөтөлбөрийн зориулалт, зорилтот түвшин, зарцуулах дүн зэргийг баталсан, 3 сум чанар, тоо хэмжээний үзүүлэлт баталсан байна. Дэлгэрэнгүйг хавсралт 2-т харуулав.

ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг батлах шалгуур үзүүлэлт, заавар журам байхгүйгээс шалтгаалан эдгээр үзүүлэлтийг батлах үйл явц хангалтгүй байна.

4.2. Сумдын ерөнхий боловсролын сургуулиудын төсвийн хуваарийг дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр 1,591.5 сая төгрөгөөр өөрчилж, 998.2 сая төгрөгийн урсгал зардлыг хөрөнгө оруулалтын зориулалтаар тендер зарлан гүйцэтгүүлсэн байна.

Дорноговь аймгийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих ерөнхий боловсролын сургуулиудын төсөвт 2019 онд ашиглалтанд орох бага сургуулийн урсгал зардалд 1,607.5 сая төгрөгийг илүү батлуулсан байна. Аймгийн Засаг даргын 2018 оны 7-р сарын 26-ны А/595 захирамжаар тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөвт өөрчлөлт оруулж, дээрх бага сургуулийн урсгал зардлын төсвийг бусад сургуулиудад нэмж хуваарилан төсвийн хуваарьт нийт 1,591.5 сая төгрөгийн өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн тухай хуулийн 15.2-т заасны дагуу аймгийн Засаг дарга нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төвлөрүүлэн захирагч болох юм. Гэтэл аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 42.4-т "төсвийн зохицуулалт хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна" гэсэн заалтыг зөрчин БСШУЯамны сайдын буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлгүйгээр дээрх зохицуулалтыг хийсэн байна.

Мөн аймгийн Засаг даргын А/595 захирамжаар сумдын сургуулиудын төсвийн хуваарийг өөрчилж, сумын ИТХ-аар батлагдсан төсвийг нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14.1.17, 39.2, 66.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төсвийн тухай хуулийн 14.1.17-д зааснаар сумын Засаг дарга нь тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд 39.2-т зааснаар тусгай шилжүүлгийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх гэрээг аймгийн Засаг даргатай байгуулах юм. Мөн Төсвийн тухай хуулийн 66.1-т зааснаар **"сумын Засаг дарга тухайн шатны төсвийг боловсруулах, батлуулах, төсвийн сар улирлын хуваарийг баталж мөрдүүлэх"** бүрэн эрхтэй байна.

Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмыг зөрчиж сумдын сургуулийн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсны улмаас сумын ИТХ-ын баталсан төсвөөс өөр дүнтэй төсвийн хуваарийг сургуулиуд мөрдөж байна. Мөн сумын тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв нэмэгдсэнээр сумын төсөвт тодотгол хийх сумын ИТХ-ын эрх зөрчигдөхөд хүрч байна.

Аймгийн Засаг даргын 2018.07.26-ны А/595 дугаар захирамжийн дагуу сумдын сургуулиудын цалин хөлс болон эд хогшил, урсгал засварын зардалд 1,591.5 сая төгрөгийг хуваарилсан. Гэтэл төсвийн хуваарьт орсон өөрчлөлтийн дагуу 13 сумын сургуулийн их засвар, тоног төхөөрөмжийн зардалд аймгийн Орон нутгийн өмчийн газраас тендер зарлан 998.2 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ. Урсгал зардлыг хөрөнгийн зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7. **"Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно"** гэсэн заалтыг зөрчсөн.

Дээрх зохицуулалтын хүрээнд Сайншанд сумын 3-р сургуулийн төсөвт 530.0 сая төгрөг нэмж хуваарилсан ба үүнээс 68.3 сая төгрөгөөр тендер зарлан гүйцэтгүүлж,

55.3 сая төгрөгийг 2018 оны 10 дугаар сард хасч одоо үлдэгдэл 406.4 сая төгрөг хэмнэгдээд байна.

4.2. Өмнөх оны үлдэгдлээс зарцуулахаар батлагдсан төсвийг хэтрүүлэн, үр ашиггүй зарцуулсан байна.

Урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрээр “бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө” гэсэн зориулалтын дагуу “бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж” зардлын ангиллаар нийт 500.0 сая төгрөгийг зарцуулахаар аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Аймгийн Засаг даргын нэр дээр төсөвт байгууллагын адил урсгал зардлын төсөв баталж байна.

Урьд оны үлдэгдлээс нийт 500.0 сая төгрөг зарцуулахаар аймгийн ИТХ-аар батлагдсан ба гүйцэтгэлээр 651.6 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 151.6 сая төгрөгөөр хэтрүүлжээ. Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2. “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Урсгал зардлын төсвөөс хөрөнгө оруулалтын шинж чанартай үндсэн хөрөнгө худалдан авах, төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, зориулалтыг зөрчин төсвийн үр ашиггүй зарцуулж Төсвийн тухай хууль тогтоомж зөрчжээ.

Аймгийн төсвийн өмнөх оны үлдэгдлийг “чөлөөт үлдэгдэл” гэж нэрлэн аймгийн Засаг даргын захирамжаар нөөц хөрөнгийн адил бусад байгууллагад дэмжлэг олгох, хөрөнгө худалдан авах зэргээр үр ашиггүй зарцуулж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.3. “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сумдын хөрөнгө борлуулсны орлого, хөрөнгийн орлогыг үйл ажиллагааны болон шууд бус орлогоос салгаж төлөвлөөгүй байна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шууд бус орлогын төрөлд хүүгийн орлого орохгүй бөгөөд хуулийн 13 дугаар зүйлд заасан хөрөнгийн орлогод хамаарч байна.
- Сайншанд, Замын-Үүд сумын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөө өмнөх онд 66-87 хувьтай биелж, орлогын төлөвлөгөө тасарсан байхад 2018 онд орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 24-25 хувиар нэмж төлөвлөсөн байна. Төлөвлөгөөг үндэслэлгүй нэмэгдүүлснээс шалтгаалж дээрх 2 сумын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөө тасарч байна.
- Сумдын ЗДТГ-ын орон тоог Засгийн газраас тогтоосон орон тооны дээд хязгаараас хэтрүүлэн төлөвлөж байна. Орон тоо, цалингийн санг төлөвлөхдөө Сангийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 4-1/4116 тоот албан бичгээр ирүүлсэн “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018-2020 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж”-ийн 4.2.14-т “ажлын ачааллыг нягтруулах замаар одоо мөрдөгдөж байгаа орон тоог нэмэгдүүлэхгүй байх зарчим баримталж, орон тоо, цалингийн санг төлөвлөх” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
- Засгийн газар 2017 оны 188 дугаар тогтоолоор улсын төсвийн болон нийгмийн даатгалын сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн орлогын доод, зарлагын дээд хязгаарыг баталсан байна. Засгийн газраас орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн зарлагын дээд хязгаарыг тогтоож өгөөгүйгээс баримтлах төсвийн хязгаар байхгүй байна. Үүний улмаас аймаг, сумдын төсвийн ерөнхийлөн захирагч нар нь зарлагын дээд хязгаар байхгүйгээс төсвийн орлогоо нэмсэн хэмжээгээр зарлагаа нэмэгдүүлэн ИТХ-аар батлуулж байна.
- Сангийн яамны хянаж ирүүлсэн сургуулиудын төсвөөс 165.3 сая төгрөгийг хасч, соёлын байгууллагуудын төсвийг 165.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдсан Зүүнбаян баг болон Иххэт сумын спорт цогцолборын барилгын урсгал зардлыг БСШУЯ, Сангийн яамнаас төсөвт суулгаж өгөхгүй байгаа үндэслэлээр дээрх хоёр салбарын санхүүжилтийг хооронд нь шилжүүлжээ.
- Сумын сургуулиудын төсвийн нийт санхүүжилтийн дүнд аймгийн Санхүү хэлтэс гэсэн нэр дээр Сайншанд суманд баригдаж, дараа онд ашиглалтанд

орох бага сургуулийн урсгал зардалд 1,607.5 сая төгрөгийг илүү батлуулсан байна. Мөн сумдын Эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдийн төсөвт “төрийн сангийн нөөц” нэрээр 18.5 сая төгрөгийг илүү хуваарилан батлуулсан.

- Сумын Засаг даргын харьяа байгууллагын төсвийн сар улирлын хуваарийг аймгийн СТСХ, ЭМГ, БСУГ-ын төсвийн мэргэжилтнүүд өөрчилж байгаа нь сумын ИТХ-ын баталсан сумын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв болон төсвийн сар улирлын хуваарь хоорондоо зөрүүтэй батлагдах, сумын Засаг дарга өөрийн харьяа байгууллагуудын төсвийг хуваарилах, батлах зэрэг хууль тогтоомжоор олгогдсон эрхээ хэрэгжүүлж чадахгүй байх нөхцөл байдалд хүргэж байна.
- Суурь зарлагад тооцох хөрөнгийн зардлыг буруу төлөвлөн зарцуулж байна. Аймгийн төсвийн орлогыг нэмэгдүүлснээс үүссэн зөрүүгээр хөрөнгийн зардлыг 3,654.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн ба энэ хэмжээгээр орон нутгийн төсвийн суурь зарлага нэмэгдсэн байна. Суурь зарлагад тооцсон хөрөнгийн зардал /орон нутгийн хөрөнгө оруулалт/ нь Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 6.1-д заасан “орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардал”-д тавигдах шаардлагыг хангахгүй байна.
- Орон нутгийн төсвийн суурь зарлагад тооцсон хөрөнгийн зардал/орон нутгийн хөрөнгө оруулалт/-ын 3,788.1 сая төгрөг буюу 68 хувь нь аймгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй байгаа бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарч байна.
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан журмын 6.1.2 дахь заалтын дагуу “үндсэн тэнцлийн ашгийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт тооцох” тухай заалт хүчинтэй хэвээр мөрдөгдөж байна. Иймд орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт тооцон төлөвлөхөөр байна.
- Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын 30 хувийг төсөвт төвлөрүүлээгүй байна. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар нийт 389.3 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого олсон гэж тайлагнасан байна.
- Сангийн сайдын баталсан улсын төсөвт төвлөрүүлэх орлогын сар, улирлын хуваарийн дагуу 2018 оны 1-3 дугаар улиралд нийт 1,876.1 сая төгрөгийг төвлөрүүлэх ёстой байсан боловч орлогын төлөвлөгөөг огт биелүүлээгүй байна.
- Доод шатны төсвөөс буюу Замын-Үүд сумын төсвөөс аймгийн төсөвт орлого төвлөрүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.2 дахь заалтыг баримтлаагүй байна. Үүний улмаас Замын-Үүд сумын төсвөөс аймгийн төсөвт 1,224.6 сая төгрөгийн орлогыг илүү татан төвлөрүүлэхээр тооцсон байна.

- Аймаг, сумын ИТХ-аар төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг харилцан адилгүй баталж байна. Зарим сумдад ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнг батлаагүй тохиолдол ч гарч байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, хүрэх үр дүн, чанарын болон тоон үзүүлэлтэд баримтлах шалгуур үзүүлэлт, заавар журам байхгүй байгаагаас шалтгаалан эдгээр үзүүлэлтийг баталж мөрдөх үйл явц хангалтгүй байна.
- Сумдын ерөнхий боловсролын сургуулиудын төсвийн хуваарийг дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр 1,591.5 сая төгрөгөөр өөрчилж, 998.2 сая төгрөгийн урсгал зардлыг хөрөнгө оруулалтын зориулалтаар тендер зарлан гүйцэтгүүлсэн байна.
- Урьд оны үлдэгдлээс зарцуулахаар батлагдсан 500 сая төгрөгийн төсвийг хэтрүүлэн 651.6 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 151.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.
- Монгол улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар тус аймагт 5 сайдын багцын хүрээнд нийт 27 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 49,074.1 сая төгрөгийн, аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын хурлаар 12,217.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 ТАХ-г хэрэгжүүлэхээр тус тус батлагдсан байна.
- Худалдан авах ажиллагаанаас улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 81.9 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 0.6 хувийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар, 2.3 хувийг харьцуулалтын аргаар, 15.2 хувийг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулжээ.
- Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг баримтлалгүйгээр улсын төсвийн байгууллагад 9 төсөл арга хэмжээг 1,896.6 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтыг төлөвлөн баталсан байна.
- Барилга байгууламжийн ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэсэн 2 ТАХ, баталгаажсан зураг төсөлгүй 3 ТАХ, зураг төсөлд өөрчлөлт оруулж ажил гүйцэтгэхдээ зохиогчоор баталгаажуулаагүй 1 ТАХ байна.
- Улсын төсвөөс санхүүжигдэн гүйцэтгэж буй барилга байгууламжийн гэрээний үүргийн хэрэгжилтэд захиалагч, зохиогчийн тавих хяналт сул байгаагаас зарим төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл чанаргүй байх, норм стандартын дагуу гүйцэтгэхгүй байх эрсдэл бий болж байна.
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 368.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.
- Аудитаар нийт 406.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 368.5 сая төгрөгийн албан шаардлага бичлээ.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ :

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.9, 23.8.13 дахь заалтын дагуу аймаг, сумын төсөвт хуваарилах газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг Сангийн яамнаас орон нутгийн төсөвт хуваарилж шилжүүлэхгүй байгаа;
- УИХ, Засгийн газраас орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн орлогын доод, зарлагын дээд хязгаарыг тогтоож мөрдүүлэх;
- Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар” нь Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан зарлагын эдийн засгийн ангилалтай тохирохгүй болсныг шинэчлэх саналыг Сангийн яаманд хүргүүлэх;
- Улсын төсвийн санхүүжилтээр салбар яамдад тендер зарлан орон нутаг гүйцэтгэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох баримт материал, техникийн тодорхойлолт, зураг төсвийг аймгийн холбогдох байгууллагуудад ирүүлдэггүйгээс орон нутгаас захиалагчийн хяналт хэрэгжүүлэх, хяналт тавих боломжгүй байдаг тул холбогдох байгууллагад баримт материалыг ирүүлж байх зөвлөмжийг салбар яамдад хүргүүлэх;
- Дорноговь аймгийн сумдын ЗДТГазар нь Засгийн газрын 2009 оны 13, 2017 оны 253 дугаар тогтоолоор баталсан орон тооны дээд хязгаарыг хэтрүүлэн ажиллаж байна. Гэтэл аймгийн СТСХэлтсээс үүнд ирүүлсэн тайлбартаа Засгийн газрын тогтоолд туслах үйлчилгээний албан хаагчдын орон тоог тогтоогоогүй гэж үзсэн байна. Иймд Засгийн газар, Сангийн яамнаас дээрх тогтоолын агуулгатай холбоотой тайлбар авч орон нутагт ирүүлнэ үү;
- Төсвийн тухай хуулийн 60.2.3 дахь заалт хүчингүй болсноор орон нутаг үндсэн тэнцлийн ашгаа орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхгүйгээр буцаан суурь зарлагаа нэмэгдүүлэх болсон тул орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгийг хэрхэн хуваарилах, зарцуулах асуудлыг тодорхой болгож өгөх зэрэг асуудлыг судлан шийдвэрлэж өгнө үү.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Нэг. Аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин танаа

- 1) Төсвийн тухай хуулийн 14.1.17-д заасны дагуу сумын Засаг дарга нь сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхийг эдлэх бөгөөд сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн сар улирлын хуваарийг баталж мөрдүүлэх, төсвийн зохицуулалт хийх эрх нь сумын Засаг даргад хамаарах тул аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн хуваарьт зохицуулалт хийхгүй байх
- 2) Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагаа үндэслэлтэй тооцож хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгах
- 3) Төсөл, арга хэмжээний үе шатны ажлын явц, хэрэгжилтэд тавьж буй захиалагч, зохиогчийн хяналтын чанарыг сайжруулах

Хоёр. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ц.Содхүү танд

- 1) Хөрөнгө борлуулсны болон хөрөнгийн орлогыг орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөнд тусгах, шууд бус орлогын төлөвлөгөөнд оруулж төлөвлөсөн бол орлогыг нэр төрлөөр ангилж төлөвлөх
- 2) Тусгай зориулалтын шилжүүлгийн болон орон нутгийн төсөвт байгууллагуудын орон тоо, цалингийн санг төлөвлөхдөө Сангийн сайдын ирүүлсэн төсвийн удирдамжид тусгасан орон тооны талаар мөрдөх зарчмыг баримтлах
- 3) Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн сар улирлын хуваарийг аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагийн газрын төсвийн мэргэжилтнүүд хуваарилж байгаа зөрчлийг арилгах, Төсвийн тухай хуулиар сумын Засаг даргад олгогдсон сумын төсөвт байгууллагуудын төсвийн хуваарийг баталж, мөрдүүлэх эрхийг зөрчихгүй байх
- 4) Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан журмын 6.1.7, 7.7 дахь заалтын дагуу төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын 30 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах
- 5) Урьд оны үлдэгдлээс зарцуулах төсвийг “бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж” зарлагын ангиллаар батлуулж, батлагдсан төсвийг хэтрүүлэн зардлыг зориулалт бусаар зарцуулж байгаа зөрчлийг

арилгах. Өмнөх оны үлдэгдлийг “чөлөөт үлдэгдэл” гэж нэрлэн зарцуулдаг зөрчлийг 2019 оны төсвийн жилээс эхлэн зогсоох. Урьд оны үлдэгдлийг төсвийн зарлагын дутагдсан эх үүсвэрийг санхүүжүүлэх зарчмаар төлөвлөх

- 6) Суурь зарлагад тооцох хөрөнгийн зардлыг Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 6.1-т заасны дагуу төлөвлөх, орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх зардлаар өөр чиг үүргийн хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхгүй байх
- 7) Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1.2-т заасны дагуу төсвийн үндсэн тэнцлийн ашгийг орон нутгийн хөгжлийн санд хуваарилах
- 8) Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг төсвийн сар улирлын хуваарийн дагуу бүрэн төвлөрүүлэх, Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг биелүүлж ажиллах
- 9) Замын-Үүд сумын төсвийн үндсэн тэнцлийн ашгийг Төсвийн тухай хуулийн 56.2-т заасны дагуу хуваарилах

Дарга, тэргүүлэх аудитор

Ч.Ариунаа

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Утас/факс: (705) 2-25-33

E-mail: dornogobi_mgl@yahoo.com


2018.11.02 № 17893

танай _____ -ны № _____ -т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагын 2018 оны төлөвлөгөөний дагуу “2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд дараах саналуудыг хүргүүлж байна.

Хавсралт **6**.... хуудастай.



Т.ЭНХТҮВШИН

02 1354

2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн
аудитын тайланд өгөх тайлбар.

2018.11.02

1. Алтанширээ сумын Соёлын төвийн их засварын ажлын зурагт дээвэр засах ажил тусгагдаагүй бөгөөд засварын ажлыг эхлэхэд дээврээс ус гоожиж байсан учир ажлын зурагт өөрчлөлт оруулж, батлагдсан төсөвт багтаан дээврийг засварлах ажлыг хамт хийж гүйцэтгэсэн болно.

2. 2018 онд аймгийн ОНХС-д 1823.8 сая төгрөг батлагдсан. Энэ хөрөнгөөр аймгийн ОНХС-ийн чиг үүрэгт хамаарах ажлуудыг төлөвлөн хийж гүйцэтгэсэн бөгөөд үлдсэн ажлуудыг аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн болно.

3. ГИХГ, Замын-Үүд НААҮОНӨ ХХК-ний хогийн бункер, ХМХА-ны тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгуулахаар Замын-Үүд сумын Засаг даргын захирамж гаргаж хүргүүлсэн тухай 2/1193 тоот албан бичгийг хавсаргав.

4. Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 20 хувийг аймгийн төсөвт, 10 хувийг сумын төсөвт тусгуулахаар аймгийн Засаг даргын 2017 оны 1/1961 дугаар албан бичгээр Сангийн сайд болон ЗГХЭГ-ын даргад хүсэлт тавьсан боловч Сангийн сайдын 2017 оны 4-2/6677 дугаар албан бичгээр энэхүү харилцааг зохицуулсан тусгайлсан журмыг гаргал орон нутгийн төсөвт тусгах боломжгүй гэсэн хариуг өгсөн болно. Энэ асуудлаар танай байгууллагад аймгийн Засаг даргын 2017 оны 1/2231 дугаар албан бичигт Сангийн сайдын албан бичгийн хавсарган хариу хүргүүлсэн болно.

5. Аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн аймгийн төсвийн төслийг аймгийн Засаг даргын албан бичгээр аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс /СТХС/-ээс боловсруулан хүргүүлдэг. СТХС нь төсвийн орлогын төлөвлөлтөнд татварын орлогын хувьд аймгийн Татварын хэлтсийн суурь мэдээлэл, тооцоо, судалгаанд үндэслэсэн орлогын төлөвлөгөөний саналыг хүлээн авч шаардлагатай тохиолдолд татварын орлогыг нэмэгдүүлэх, эсхүл бууруулах өөрчлөлтүүдийг хийн хянан боловсруулж, татварын бус орлого, хөрөнгийн орлогын төлөвлөгөөний дүнтэй нэгтгэн аймгийн төсвийн орлогын төлөвлөлтийг хийдэг. Аймгийн ИТХ-аар сумдын төсвийг баталдаггүй, тухайн төсвийн жилийн боломжит орлого, зарлагын хэмжээг хяналтын тоо хэлбэрээр хүргүүлдэг. Сумд өөрийн сумын төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөнд боловсруулалт хийн нэмэгдүүлэх, бууруулах, эсхүл өөрчлөлтгүйгээр баталж байгаа. Өөрчлөлт хийгээгүй баталж байгаа тохиолдлыг сумын санхүүгийн алба төсвийн орлогын төлөвлөлтөд оролцдоггүй гэх үндэслэлгүй бөгөөд аймгийн Татварын алба, Татварын улсын байцаагчид тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагчдыг татварын хууль тогтоомж, тухайн нэр төрлийн татварын орлогын гүйцэтгэлийн явц, төсөвт орох боломжит хэмжээ зэрэг татвартай холбоотой бүхий л мэдээллээр хангаж, орон нутгийн удирдлагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах чиг үүрэгтэй тул төсвийн орлогын төлөвлөлтөнд оролцож байгаа үйл ажиллагааг буруутгах шаардлагагүй юм.

6. 2018 оны төсвийн орлогыг Сангийн ямаар хянуулахдаа үйл ажиллагааны орлого 1900,0 сая төгрөг, хөрөнгө /хадгаламжийн хүү/-ийн орлогын татварыг 550,0 сая төгрөгөөр, шууд бус орлого /хувь хүнээс суутгасан орлогын татвар/-ыг 450,0 сая төгрөгөөр тус тус хянуулсан ба аймгийн ИТХ-аар нийт дүнгээр үйл ажиллагааны орлогыг 2186,9 сая төгрөгөөр, үүнээс хөрөнгө борлуулсны орлогын татварыг 230,0 сая төгрөг, хөрөнгө /хадгаламжийн хүү/-ийн орлого 698,8 сая төгрөгөөр, шууд бус орлого /хувь хүнээс суутгасан орлогын татвар/-ыг 334,0 сая төгрөгөөр баталсан. Сумд дээрх орлогууд сумын ИТХ-аар мөн батлуулсан. Хөрөнгө борлуулсны орлогын татварын хэмжээг сум тус бүрээр хавсаргав.

Төсвийн тухай хуулийн 23.8-д “Сумын төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ”, 23.8.1-д “ХХОАТ-ын туай хуулийн 8.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад ХХОАТатвар орно” гэж заасны дагуу 2018 онд дээрх төрлийн орлогыг нийт дүнгээр батлуулж, үүнээс үйл ажиллагааны орлого, хадгаламжийн хүүгийн орлого, хөрөнгө борлуулсаны орлогуудыг тус бүрд нь салгаж төлөвлөсөн.

Сангийн яам хөрөнгө борлуулсны орлогын татварын төлөвлөгөөг 2018 оны төсөвт хянахдаа Төсвийн тухай хуулийн 23.8.1-д заасан татварын орлогын төрөлд оруулан тооцож 215,0 сая төгрөгөөр хянасан. ХХОАТ-ын хуулийн 14.1.1-д “Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого” гэсэн заалт байдаг боловч улсын хэмжээнд мөрдөж байгаа төсвийн гүйцэтгэлийн мэдээний программд хөрөнгө борлуулсаны орлого гэсэн нэр төрөл байдаггүй, үйл ажиллагааны орлого гэсэн нэр төрөлд оруулдаг ба татварыг төсөвт төвлөрүүлэхдээ сум бүрт тусгай данс /10006....962/-нд төвлөрүүлдэг. 2018.09.30-ны байдлаар сум тус бүрийн хөрөнгө борлуулсны орлогын татварын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хавсаргав.

ХХОАТ-ын 13.1.4-т заасан хүүгийн орлогыг хөрөнгийн орлогод хамааруулж аймгийн ИТХ-аар 698,9 сая төгрөгийг төлөвлөж батлуулсан. Сумд ч энэ нэрлийн орлогын төлөвлөгөөг сумын төсвийн орлогын төлөвлөгөөндөө батлуулсан байгаа. Хадгаламжийн хүүгийн орлогын татварыг Төрийн сангийн /10006....975/ дансанд төвлөрүүлж байгаа болно.

Хог хаягдлын хураамжийн хувьд аймгийн статистик мэдээллээс суурь тоог авч төлөвлөлтийг хийсэн бөгөөд сайншанд сум 7200 өрх, 55 ААНБ, 214 үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагад хог хаягдлын хураамжийг ногдуулж 186,0 сая төгрөгөөр, Замын-Үүд суманд 5000 өрх, 37 ААНБ, 182 үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагад 122,2 сая төгрөгийн хог хаягдлын хураамж ногдуулан төлөвлөсөн нь өмнөх оны хог хаягдлын хураамжийн орлогын тасалдалтай холбоогүй юм.

7. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 253 дугаар тогтоолыг үндэслэл болгон аймгийн Засаг даргын 2018 оны А/340 дүгээр захирамжаар сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаар, ажлын байрны тодорхойлолтод тусган хэрэгжүүлэх ажлыг чиглэлийг батласан.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/340 дүгээр захирамжаар батлагдсан Сумдын ЗДТГ-ын бүтцийг Засгийн газраас тогтоосон орон тоотой харьцуулсан байдал

№	Сумын нэр	Хүн амын тоо	Засгийн газрын тогтоолоор	Аймгийн Засаг даргын Захирамжаар
1	Айраг	3811	14	12
2	Алтанширээ	1327	11	11
3	Даланжаргалан	2749	13	12
4	Дэлгэрэх	1873	13	12
5	Иххэт	2108	13	12
6	Замын-Үүд	18241	19	19
7	Мандах	1587	13	12
8	Өргөн	2004	13	12
9	Сайншанд	24772	21	20
10	Сайхандулаан	1380	11	11
11	Улаанбадрах	1470	11	11
12	Хатанбулаг	2919	13	12
13	Хөвсгөл	1573	13	12
14	Эрдэнэ	2378	13	12

Дээрх хүснэгтээс харахад Засгийн газрын тогтоосон орон тооны хязгаарыг хэтрүүлээгүй харин багаар тогтоосон байгаа тул орон тооны тогтоосон дээд хязгаарыг нэмэгдүүлсэн гэж үзэх үндэслэлгүй юм.

Засгийн газрын тогтоолоор сумдын ЗДТГ-ын орон тооны дээд хязгаарыг тогтоохдоо байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах туслах үйлчилгээний ажилчдын орон тоог тогтоогоогүй, Засаг даргын захирамжинд батлагдсан төсөв, цалингийн сандаа багтаан ажиллуулахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосон заалт оруулсан.

8. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар манай аймаг 2018 онд 30707,7 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгийн орлого авахаар хуульчлагдсан ба аймаг, сумын ИТХ-аар энэхүү хэмжээг ямар нэгэн байдлаар өөрчлөөгүй. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг төсвийн байгууллагуудын өөрийн орлогыг нэмэгдүүлэх замаар Сангийн яамнаас хянасан урсгал зардлын дүнг нэмэгдүүлсэн. Иймд “1.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын урсгал зардлыг илүү төлөвлөн батлуулсан байна.” гэдэг дүгнэлттэй санал нийлэхгүй байна. Харин БСШУС-ын сайдын төсвийн багцаас аймагт хуваарилсан нийт төсвийн дүнг нэмэгдүүлэхгүйгээр дотор нь зохицуулалт хийн хөтөлбөр хооронд буюу ерөнхий боловсролын сургуулийн төсвөөс соёлын байгууллагад төсөв шилжүүлсэн. Энэхүү асуудлаар БСШУС-ын сайдаас зөвшөөрөл хүсч удаа дараа хандсан ба зөвшөөрсөн хариу БСШУС-ын сайдын 2017 оны 1а/10475 дугаар албан бичгээр ирсэн болно. Уг бичгийн хуулбарыг аудитын явцад танай байгууллагад өгсөн болно.

9. Сайншанд суманд баригдах 320 хүүхдийн сургуулийн барилгыг Монгол Улсын 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн хийж, ашиглалтанд оруулах саналыг холбогдох яаманд хүргүүлсэн ба төсөв батлагдах явцад төсвийн хөрөнгийн боломжоос шалтгаалан дараа онд дамжин хийгдэхээр болсон асуудал юм. Иймд “Төсвийн төлөвлөлтөнд тавих хяналт сул байгаагаас дараа онд ашиглалтанд орох бага сургуулийн урсгал зардлыг илүү төлөвлөн батлуулжээ” гэсэн дүгнэлтийг өөрчлүүлэх саналтай байна.

10. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг төсвийн байгууллагуудын төсөв нь орон нутгийн төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг мөн тул аймгийн ИТХ-аар орж батлагдах ёстой ба аймгийн ИТХ-д өргөн баригдаж буй төсвийн төсөлд сум, байгууллагаар хуваарилганд тусгагдаж байгаа. Ингэж сум, байгууллагаар хуваарилсан төсвийг сумдын ИТХ хэлэлцэн өөрчлөлт оруулахгүй баталж байгааг сумын Засаг даргын бүрэн эрхэд халдаж байгаа мэтээр дүгнэлт гаргах нь зохисгүй юм. Аймгаас олгож буй тусгай зориулалтын шилжүүлгийн дүнг өөрчлөхгүйгээр төсвийг нэмэгдүүлэх, хорогдуулах эрх нь нээлттэй байгаа. Мөн аймгийн Засаг даргын баталсан тусгай зориулалтын шилжүүлгийн сарын хуваарийн дүнг өөрчлөхгүйгээр төсвийн байгууллагуудынхаа төсвийн сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулах эрх нь сумын Засаг даргад нээлттэй бий. Мөн БСУГ, ЭМГ-ын төсвийн мэргэжилтнүүд нь орон нутагт тухайн салбарын төсвийг төлөвлөх, хуваарилах, гүйцэтгэлд нь хяналт тавих, холбогдох тооцоо судалгаа хийх, удирдлагуудыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэх нь ажлын байрны тодорхойлолтод нь тусгагдсан ажил бөгөөд салбарын төсвийн сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулахдаа сум, төсвийн байгууллагуудын санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэдэг ба байнга салбарын төсвийн шууд захирагч нартай холбоотой ажилладаг болно.

11. Мөн орон нутгийн ТЕЗ нарын төсвийн хязгаарыг баталж өгөөгүйгээс төсвийн зарлагын хэмжээг нэмэгдүүлж байна гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Учир нь аймаг, сумын ТЕЗ нар төсвийн орлогын нөөц боломжийг дайчлан аймаг, сум орон нутгаа хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх, төсвийн багцад хамаарах байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах, засвар үйлчилгээ хийх, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай үзүүлэх хуульд тусгагдсан бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэх эрхтэй билээ. Аймаг, сумын ИТХ бүрэн эрхийнхээ хүрээнд аймаг орон нутгийн төсвийг батлах эрхтэй.

12. Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу 2017-2018 онд төсвийн байгууллагууд орлогыг төлөвлөж үйл ажиллагаагаа санхүүжүүлэх хүсэлт ирүүлээгүй.

Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын 7.1, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг төсвийн байгууллага тусгай дансаар дамжуулан эдийн засгийн ангиллаар зарцуулна гэж заасан. Төрийн байгууллагуудын нэмэлт төсвийг зарцуулах хүсэлтийг 2 дугаар хавсралтын долоод заасан бичиг баримтыг үндэслэн зарцуулах эрхийг нээж хэвийн үйл ажиллагааг хангах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан.

oooOooo

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Аймгийн Засаг даргын 2018 оны 11 сарын 02-ны 1/1893 тоот албан бичигт өгөх тайлбар:

Аудитын тайланд ирүүлсэн саналыг хүлээн авч доорх тайлбарыг өгч байна. Үүнд:

1. Танай байгууллагын ирүүлсэн саналын 1-4 дэх заалтад аудитаар илэрсэн асуудалтай холбоотой хийсэн ажлыг бичиж ирүүлсэн тул хариу тайлбар шаардлагагүй байна.
2. Саналын 5-д ирүүлсэн тайлбарт “сумын санхүүгийн алба төсвийн орлогын төлөвлөлтөд оролцдоггүй гэсэн нь үндэслэлгүй” гэсэн байна. Аудитаар Замын-Үүд, Өргөн, Эрдэнэ зэрэг сумдад ажиллаж сумын санхүүгийн албанаас энэ талаар тайлбар тодруулга авахад төсвийн орлогын төлөвлөлтийг сумын Татварын байцаагч хийж байгаа, орлогын төлөвлөгөөний төслийг аймгийн ИТХурал хуралдсаны дараа сумын санхүүгийн алба хүлээн авч нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг хэлэлцдэг гэсэн байна. Мөн Айраг, Мандах, Хөвсгөл зэрэг сумдтай холбогдож нэмэлт тайлбар авсан. Аудитын тайланд орлогын төлөвлөгөөг хянах, өөрчлөлт оруулах, батлуулах зэрэгт сумын санхүүгийн алба оролцдоггүй гэж бичээгүй бөгөөд “сумдын санхүүгийн албаны гаргаж өгсөн тайлбарт үндэслэн орлогыг төлөвлөх үйл явцад оролцоо бараг байхгүй байна” гэж бичсэн.
3. Саналын 6 дахь хэсэгт “сумд дээрх орлогыг сумын ИТХ-р батлуулсан, хөрөнгө борлуулсны орлогын татварын хэмжээг сум тус бүрээр хавсаргаж” гэсэнд өгөх тайлбар: Зарим сумын ИТХ-ын хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөөг жишээ болгож оруулаа.

ДОРНОГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

12 сарын 06 өдөр Дугаар 05/02 Дорноговь аймаг, Эрдэнэ сум

Эрдэнэ сумын 2018 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай 18.1.2 /б/ дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, Аймгийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 сарын 01 өдрийн 6/02 дугаар тогтоолыг болгон сумын 2018 оны орон нутгийн төсвийн төслийг хэлэлцээд сумын Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг: Сумын 2018 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор баталсугай.

	/мянган төгрөг/
Сум төсвийн орлого бүгд	1516019.3
I Урсгал орлого	90795.4
II Сум/ төсвийн татварын орлого	89295.4
II.1 Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	11950,0
II.2 бууны албан татвар	2115,0
II.3 Хөрөнгө борлуулсаны орлого	1400,0
II.4 Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж	1400,0

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын
07 өдрийн хуралдааныг тоот тогтоолын хавсралт

**ЗАМЫН-ҮҮД СУМЫН ОРОН НУТГИЙН 2018 ОНЫ ТОДОТГОСОН
ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ТОО**

/мянган төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	Хянасан	тодотгосон	Зөрүү
ИТ ОРЛОГЫН ДҮН	4092275.4	4821686.8	729411.4
ТАЛ ОРЛОГО	4092275.4	4821686.8	729411.4
ТАТВАРЫН ОРЛОГО	3365275.4	3664623.0	299347.6
Орлогын албан татвар	2142000.0	2142000.0	0.0
Хувийн амын орлогын албан татвар	2142000.0	2142000.0	0.0
Цалин хөлс түүнтэй адилтгах бусад орлого			0.0
Үйл ажиллагааны орлогын татвар	1844000.0	1844000.0	0.0
ТӨТБТАҮХЭИОАТатвар			0.0
Хувийн мал бүхий иргэний татвар			0.0
Хөрөнгө борлуулсны татвар			0.0
Бусад орлогын татвар	298000.0	298000.0	0.0
Хувь хүний орлогын албан татварын буцаалт			0.0

Иймд танай байгууллагын ирүүлсэн “хөрөнгө борлуулсны орлогыг сумын ИТХ-аар батлуулсан” гэдэг тайлбар нь үндэслэлгүй юм. Аудитын тайланд оруулсан мэдээлэл нь Сангийн яамны 2018 оны 9-р сарын орлогын мэдээнд үндэслэсэн бөгөөд аймгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг доор харуулав.

UZUULELT	9 sariin tosov /osson/	9 sariin guicetgel /osson/
0001 Төрийн сангийн дансны эхний үлдэгдэл	0.00	656,636,538.53
0002 НИЙТ ОРЛОГО	18,400,530,500.00	24,204,091,749.64
0003 ТАТВАРЫН ОРЛОГО	17,083,966,500.00	17,305,690,830.62
0004 Орлогын албан татвар	10,165,384,300.00	10,864,428,575.75
0005 Хувь хүний орлогын албан татвар	11,066,984,300.00	11,698,935,955.53
0006 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	8,700,000,000.00	8,915,486,307.97
0007 Үйл ажиллагааны орлого	1,630,813,100.00	1,644,898,022.10
0009 Хөрөнгө борлуулсны орлого	0.00	171,415,081.00
0013 Шууд бус орлого	736,171,200.00	967,136,544.46
0014 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-901,600,000.00	-834,507,379.78

Ирүүлсэн саналын 6-д “Төсвийн тухай хуулийн 23.8, 23.8.1-т заасны дагуу 2018 онд дээрх төрлийн орлогыг нийт дүнгээр батлуулж, үйл ажиллагааны орлого, хадгаламжийн хүүгийн орлого, хөрөнгө борлуулсны орлогуудыг тус бүрт нь салгаж төлөвлөсөн” гэж бичсэн нь аудитын тайланд дурдсан “сумдын санхүүгийн албаны өгсөн тайлбараар хөрөнгө борлуулсны болон хадгаламжийн хүүгийн орлогыг үйл ажиллагааны орлого, шууд бус орлогын төлөвлөгөөнд тусгасан” гэсэнтэй тохирч байна.

Мөн “төсвийн төлөвлөлтийн програмд “хөрөнгө борлуулсны орлого” гэсэн нэр төрөл байдаггүй” гэсэн санал ирүүлсэн бөгөөд Сангийн яамны төсвийн орлогын мэдээнд дээрх орлогын нэр төрөл тусгагдсан байна. Иймд програмд орлогын нэр төрөл байхгүй бол уг асуудлыг Сангийн яамны системийн админд хандан шийдвэрлүүлэх боломжтой бөгөөд энэ нь орлогыг төлөвлөхгүй байх шалтгаан болохгүй.

Үүнээс үзэхэд сумдын хөрөнгө борлуулсны болон хөрөнгийн татварыг нэр төрлөөр нь төлөвлөөгүй бөгөөд хэрвээ өөр орлогод оруулж төлөвлөсөн бол нэр төрлөөр нь зөв ангилан төлөвлөх тухай зөвлөмжийг аймгийн СТСХ-ийн даргад өгсөн болно.

Хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувьд Сайншанд сум болон Замын-Үүд сумын санхүү, төрийн сангийн тасгийн холбогдох тайлбар, тооцоог доор харуулав. Сайншанд сумын хувьд нарийвчилсан тооцоог гаргаж ирүүлсэн бөгөөд статистик мэдээний дагуу төлөвлөсөн тоо болон багийн албанаас авсан судалгаан дээр үндэслэн орлогын боломжит тооцоог гаргасан байна. Үүнд статистик мэдээнээс тухайн хаяг дээр амьдардаггүй, шилжин явсан зэрэг айл өрхүүдийг хасч 2018 онд төлбөл зохих хураамжийг тооцсон байна. Сайншанд сумын хог хаягдлын хураамжийн тайлбар:

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөлт

Баг	Өрхийн тоо	Нийт ногдол	Өрхийн тоо	Нийт ногдол	Өрхийн тоо	Нийт ногдол
	Төлөвлөсөн тоо /2017 оны хүн амын статистик/		Боломжит тоо		Огт төлөөгүй айл өрх	
1-р баг	орон сууц	588	7,056,000	323	3,876,000	
	гэр байр	632	11,376,000	445	8,010,000	
	нийт-1	1,220	18,432,000	768	11,886,000	
2-р баг	орон сууц	658	7,896,000	672	8,064,000	
	гэр байр	706	12,708,000	329	5,922,000	
	нийт-2	1,364	20,604,000	1,001	13,986,000	
3-р баг	орон сууц	877	10,524,000	503	6,036,000	
	гэр байр	942	16,956,000	540	9,720,000	
	нийт-3	1,819	27,480,000	1,043	15,756,000	
4-р баг	орон сууц	401	4,812,000	272	3,264,000	
	гэр байр	430	7,740,000	282	5,076,000	
	нийт-4	831	12,552,000	554	8,340,000	
5-р баг	орон сууц	547	6,565,091	331	3,972,000	
	гэр байр	31	556,364	29	522,000	
	нийт-5	578	7,121,455	360	4,494,000	
6-р баг	орон сууц	410	4,920,000	120	1,440,000	
	гэр байр	440	7,920,000	334	6,012,000	
	нийт-6	850	12,840,000	454	7,452,000	
7-р баг	орон сууц	341	4,092,000	304	3,648,000	
	гэр байр	366	6,588,000	167	3,006,000	
	нийт-7	707	10,680,000	471	6,654,000	
НИЙТ	орон сууц	3,822	45,865,091	2,525	30,300,000	
	гэр байр	3,547	63,844,364	2,126	38,268,000	
	нийт өрх	7,369	109,709,455	4,651	68,568,000	
ААНБ, хувь хүн			60,390,000		60,390,000	
нийт тооцсон орлого			170,099,455		128,958,000	
нийт төлөвлөгөөт орлого			186,040,000		186,040,000	
төлөвлөгөөний зөрүү	хэмжээ		(15,940,545)		(57,082,000)	
	эзлэх хувь		-9%		-31%	

Сайншанд сумын Санхүү, төрийн сангийн тасаг 2018.10 сар

Замын-Үүд сумын хувьд мөн уг орлого 30 хувиар тасрах магадлалтай гэсэн тайлбарыг гаргаж өгсөн. Замын-Үүд сумын хог хаягдлын хураамжийн орлогын тайлбар:

34 үйл ОН Орлого

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт
тайлбар гаргах нь

№	Асуудал	Санхүүгийн алба	Татварын тасаг
1	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг төсвийн орлогын төлөвлөгөөнд тусгаагүй буюу төлөвлөөгүй талаар тайлбар?	тал - үйл	ХХОАТ-ын төлөвлөгөөнд тусгагдсан
2	Хадгаламжийн хүүгийн орлогын албан татварыг төсвийн орлогын төлөвлөгөөнд тусгаагүй буюу төлөвлөөгүй талаар тайлбар?	төлөвлөгөөнд	ХХОАТ-ын төлөвлөгөөнд тусгагдсан
3	Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар /тасарч байгаад тайлбар/ тал үйл 7000 → 2352.2 336%	Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг манай суманд хайрга олборлогдог МЦТТ ХХК-аас ноогдлыг 100 хувь төвлөрүүлэн ажиллаж байна. мөн хувиараа хайрга олборлогдог иргэдээс 1000,0 мянган төгрөгийн төвлөрүүлж ажилласан байна. Энэ оны эцэст 50% төвлөрөх боломжтой төлөвлөгөөг АИТХ-аас өндөр баталж ирсэн байна.	
4	Хог хаягдлын үйлчилгээний орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар /тасарч байгаад тайлбар/ 74000 → 17673.4 23.9%	Хог хаягдлын хураамжийн орлогыг айл өрхөөс 4 сараас хэсгийн ахлагч нар хураан авч эхэлсэн. 2018 онд нийт айл өрхөөс 47028,0 мянган төгрөг төвлөрөхөөс эхний 9 сарын байдлаар 7700,0 мянган төгрөг төвлөрч 21,8 хувьтай байна. Аж ахуйн нэгжээс нийт 38172,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 12900,0 мянган төгрөг төвлөрүүлж 45 хувийн биелэлтэй ажиллаж байна. 2018 оны 4 улирлаас БЗӨЦТС-тай гэрээ байгуулан ажиллахаар төлөвлөөд байна. Ингэсэн хэдий ч хог хаягдлын хураамжийн төлбөрийг өндөр төлөвлөсөн тул 30 хувиар тасрах магадлалтай байна.	

4. Ирүүлсэн саналын 7 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоосон орон тооны хязгаарыг хэтрүүлээгүй, харин багаар тогтоосон” гэж үзсэн нь үндэслэлгүй байна. Танай байгууллагаас гаргаж ирүүлсэн хүснэгтийг үзвэл ЗГ-ын тогтоол, Засаг даргын захирамжаарх тоог хооронд нь харьцуулсан байна. Үүнийг аймаг, сумын ИТХ-аар баталсан орон тоо, одоо ажиллаж байгаа орон тооны гүйцэтгэлтэй харьцуулбал бүгд ЗГ-ын тогтоосон дээд хязгаараас хэтэрсэн. /аудитын тайлангийн 9 дүгээр хуудас, эх сурвалж: сумдын ИТХ-ын тогтоол, төсвийн гүйцэтгэлийн мэдээ/

Мөн ирүүлсэн саналдаа “Засгийн газрын тогтоолоор сумдын ЗДТГ-ын орон тооны дээд хязгаарыг тогтоохдоо байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах туслах үйлчилгээний ажилчдын орон тоог тогтоогоогүй” гэсэн нь үндэслэлгүй байна. Засгийн газраас тогтоосон орон тооны дээд хязгаар гэдэгт сумын ЗДТГ-т байх улс төрийн, төрийн захиргааны, төрийн үйлчилгээний үндсэн орон тоонд хамаарах бүх албан хаагчдыг хамруулж ойлгохоор заасан байна. Гэтэл ЗГ-ын тогтоолыг мушгин гуйвуулах замаар илэрсэн зөрчлийг /орон тооны дээд хязгаар хэтрүүлсэн/ хаацаалайх нь зохисгүй юм. Засгийн газрын тогтоолын агуулгыг доор харуулав. Үүнд:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн амтай суманд 13, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15, 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 21, 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай

Цаашид орон тоог батлахдаа Засгийн газрын тогтоол, төсвийн удирдамж зэргийг баримталж ажиллахыг аудитаар зөвлөмж болгон хүргүүлсэн.

5. Ирүүлсэн саналын 8-д “БСШУС-ын төсвийн багцаас аймагт хуваарилсан нийт дүнг нэмэгдүүлэхгүйгээр ерөнхий боловсролын сургуулийн төсвөөс хасч соёлын байгууллагад төсөв шилжүүлсэн” гэсэн тайлбарыг хүлээн авч, нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан төсөв тул тайланд өөрчлөлт орууллаа.

Харин “энэхүү асуудлаар БСШУС-ын сайдаас зөвшөөрөл хүсч удаа дараа хандсан ба зөвшөөрсөн хариу БСШУС-ын 2018 оны 1а/10475 дугаар албан бичгээр ирсэн болно. Уг бичгийн хуулбарыг аудитын явцад танай байгууллагад өгсөн болно” гэсэн санал, тайлбар үндэслэлгүй байна.

БСШУС-ын сайдад хандаж 2018 оны 6,7-р сард явуулсан бичиг аудитын явцад үзүүлээгүй бөгөөд аймгийн Засаг даргаас Сангийн сайдад хандан 2018 оны 6 сарын 26-ны өдөр явуулсан 1/1225 тоот албан бичгийг ирүүлсэн байна. Улмаар Сангийн сайд болон БСШУС-ын сайдын зөвшөөрсөн албан бичиг ирээгүй байхад аймгийн Засаг дарга 2018 оны 7 сарын 26-ны А/595 захирамжаар тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, сумдын сургуулийн төсвийг “илүү батлуулсан 320 хүүхдийн бага сургууль”-ийн төсвөөр нэмэгдүүлж Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг зөрчсөн.

Мөн “зөвшөөрсөн хариу БСШУС-ын 2018 оны 1а/10475 дугаар албан бичгээр ирсэн ба үүний хуулбарыг танай байгууллагад аудитын явцад өгсөн” гэсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

БСШУС-ын сайдын 2018 оны 09 сарын 06-ны 1а/10475 дугаар албан бичиг нь Засгийн газрын 2018 оны 8-р сарын 22-ны өдрийн 264 дүгээр тогтоолоор төсвийн

ерөнхийлөн захирагч нарт төсөвтөө зохицуулалт хийхийг зөвшөөрсөнтэй холбоотой ирсэн албан бичиг байна. ЗГ-ын 2018 оны 264 дүгээр тогтоолын 2.Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтооход шаардагдах хөрөнгийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийж шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай” гэж заасны дагуу 2018 оны 9-р сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн байна. Үүнтэй холбоотой БСШУС-ын сайд 2018 оны 09 сарын 06-ны 1а/10475 албан бичгийг ирүүлжээ.

Иймд Засгийн газрын 2018 оны 8-р сарын 264 дүгээр тогтоолтой холбогдон ирсэн албан бичгийг 2018 оны 7-р сард төсвийн хуваарь өөрчлөхөөр гаргасан аймгийн Засаг даргын захирамжтай холбоотой мэтээр бидэнд ойлгуулахыг оролдох нь зохисгүй байна.

6. Ирүүлсэн саналын 9, 11, 12 дахь хэсэг нь аудитын тайланд дэлгэрэнгүй бичигдсэн тул хариу тайлбар бичих шаардлагагүй гэж үзлээ. Харин саналын 10 дахь хэсэгт дараах тайлбарыг өгч байна.

Сумын Засаг даргаас харьяа төсвийн шууд захирагчдын төсвийн хуваарийг баталж мөрдүүлэх байтал аймгийн Засаг даргаас сумын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн хуваарийг нэмэгдүүлэх өөрчлөлтийг хийсэн нь Төсвийн тухай хууль болон холбогдох бусад журмыг зөрчсөн тухай аудитын тайланд дурдсан. Аймгийн Засаг дарга захирамж гарган сумдын сургуулийн төсвийг нэмэгдүүлсэн нь сумын ИТХ-аар баталсан сумын сургуулийн төсвийн дүн өөрчлөгдөх байдалд хүргэж энэ нь сумын ИТХ, сумын Засаг даргын төсвийн талаарх бүрэн эрх зөрчигдсэн тухай асуудал юм.

Мөн “аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагийн газрын төсвийн мэргэжилтнүүд нь орон нутагт тухайн салбарын төсвийг төлөвлөх, хуваарилах, гүйцэтгэлд нь хяналт тавих чиг үүрэг ажлын байрны тодорхойлолтод нь тусгагдсан тул сумын төсвийн байгууллагуудын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг” гэсэн санал ирүүлсэн.

Аймгийн ЭМГ, БСУГ нь төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд шууд БСШУС-ын сайдад харьяалагддаг бөгөөд ЭМГ, БСУГ-ын төсвийн мэргэжилтнүүд нь сумын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьдаггүй, энэ чиг үүргийг аймаг, сумын СТСХэлтэс гүйцэтгэж байна.

Төсвийн гүйцэтгэлд нь хяналт тавих чиг үүрэг байхгүй тул төсвийг хуваарилах, төлөвлөх чиг үүргийг аймгийн ЭМГ, БСУГ-ууд хэрэгжүүлэхгүй гэж ойлгоно. Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 болон 66 дугаар зүйл, холбогдох журмын заалтуудаар тодорхой зохицуулагдсан байна.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/24

Дорноговь аймаг, Сайншанд сум

Санхүүгийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.12, 15.2.2, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Монгол улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”, 2017 оны 188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУ-ын Ерөнхий аудиторын баталсан 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, аймгийн Төрийн аудитын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн “2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц” сэдэвт санхүүгийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийн түр үүргийг орлон гүйцэтгэгч /Ц.Лүндэгмаа/-д үүрэг болгосугай.
4. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА



9825965

Аудитын тайланг хянаж баталгаажуулсан:

Дарга, тэргүүлэх аудитор

Ч.Ариунаа

Аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Лүндэгмаа

Аудитыг гүйцэтгэсэн:

Ахлах аудитор

Л.Аваадорж

Аудитор

Б.Тунгалагтуяа

2018 оны 11 дүгээр сарын 05